

**БАЯНХОНГОР АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2025 оны 06 дугаар сарын 12

Рашаант

Улсын бүртгэлийн ерөнхий хууль болон хууль тогтоомжид заасан улсын бүртгэлийн байгууллагын бүрэн эрх, чиг үүргийн хүрээнд Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь 2025 онд дэвшүүлсэн зорилт, Засгийн газрын тогтоолоор батлагдсан хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээг шуурхай, чанартай хүргэх үндсэн үйл ажиллагааны зэрэгцээ Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн зөвлөмж чиглэлийг удирдлага болгон бүртгэлийн ажил үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах, БҮТЭЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ зорилтыг хангах ажилд онцгойлон анхаарал хандуулан ажиллалаа.

Улсын бүртгэлийн хэлтэс хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, улсын бүртгэгчийн үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах, улсын бүртгэлийн эх нотлох баримт бичгийн цаасан болон цахим архив, цахим мэдээллийн санг үүсгэх, хөтлөх, төрөлжүүлэн хадгалах, тэдгээрийн хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах, улсын бүртгэлийн хөтлөлт, эх нотлох баримтын үнэн зөвийг нягтлан бүрдлийг хангах, илэрсэн зөрчлийг арилгуулах замаар улсын бүртгэлийн үнэн зөв, бодит байдлыг хангах зэрэг үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллав.

Мөн хэлтсийн нийт албан хаагчдад Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хуулийг чанд мөрдөн, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахин, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх, үйлчилгээний стандартыг баримтлан ажиллахыг үүрэг болгон мэргэжлийн удирдлагаар ханган ажиллалаа.

Хэлтсийн 2025 оны эхний хагас жилийн энэхүү тайланд хууль тогтоомж болон үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хэрхэн зохион байгуулсан, байгууллагын стратеги зорилтыг хангах зорилгоор нэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээнд хамрагдсан болон хэлтсийн хэмжээнд хийгдсэн ажил, улсын бүртгэгч нарын хийж гүйцэтгэсэн ажил, үйлчилгээг нэгтгэн танилцуулж байна.Үүнд:

- Хөтөлбөр ,төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар;
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын НӨХӨН СОНГУУЛ-ийн бэлтгэл ажил, зохион байгуулалт

- Улсын бүртгэлийн (иргэнийн, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн) үйлчилгээг түргэн шуурхай, чанартай хүргэх ажлын зохион байгуулалт;
- Бүртгэлийн хяналт;
- Санхүү, төсвийн удирдлага, төлөвлөлт болон төсвийн гүйцэтгэл;
- Байгууллагын дотоод ажил, үйл ажиллагааг сурталчлах ажиллагаа;
- Байгууллагын албан хаагчийн сургалт, хөгжил, ёс зүй;
- Орон нутаг дахь хамтын ажиллагаа;
- Идэвхи санаачилга, шинэлэг ажил

НЭГ.ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг УБЕГ-аас батлан ирүүлсэн хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, зарим тохиолдолд хэлтсээс дэд хөтөлбөр, төлөвлөгөөг батлан хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Жишээлбэл:

1.1.1 Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

1.1.2 Жендэрийн тэгш байдлыг хангах дэд хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт

1.1.3 Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх дэд төлөвлөгөөний хэрэгжилт

1.1.4 Улсын бүртгэлийн Ерөнхий газрын хүүхдийн төлөө зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

1.1.5 Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт

1.1.6 Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүний эрхийг ханган дэд төлөвлөгөөний хэрэгжилт

1.1.7 Байгууллагын эрсдлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөний хэрэгжилт гэх мэт.

Дээрх төлөвлөгөөнүүдийн хэрэгжилтийг хангах ажлыг хариуцан зохион байгуулах ажилтан, албан хаагчдийг жил бүр томилон түүний гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгуулан биелэлтийг хангуулан ажиллаж байна. Дурьдвал Улсын бүртгэлийн байгууллагын жендэрийн нэгдсэн бодлогын үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч А.Оюунсүвд хариуцан хэрэгжүүлдэг бол хуулийн этгээдийн улсын бүртгэгч Д.Отгонсүрэн Авлигаас урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх дэд төлөвлөгөөний хэрэгжилтийг, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч С.Баярмаа “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”

төлөвлөгөөний хэрэгжилт, эцэг эхийн зөвлөл, хүүхдийн зөвлөлийн асуудал, иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд ахлах бүртгэгч П.Бүжинлхам Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүний эрхийг хангах дэд төлөвлөгөө, Байгууллагын эрсдлийн төлөвлөгөө гэх мэт хариуцан хэрэгжилтийг тайлагнан ажиллаж байна.

Төлөвлөгөөнүүдийг хариуцсан албан хаагчид хэрэгжүүлж биелэлтийг гарган тогтоосон хугацаанд цахимаар хүргүүлсэн байна.

ХОЁР. СОНГУУЛИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

2.1.”Улсын бүртгэлийн сонгуулийн цахим системд оруулсан орон нутгийн нөхөн сонгуулийн Сонгогчдын нэрийн жагсаалтыг шалгасан тухай”

Улсын бүртгэлийн сонгуулийн цахим системд оруулсан орон нутгийн нөхөн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтыг хэсэг тус бүрээр шалгасан талаар 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр Илтгэх хуудсаар тайлагнасан ба тайлангаар хийгдсэн ажлын талаар товч тоймловол;

1.Улсын бүртгэлийн сонгуулийн системд оруулсан Сонгогчдын нэрийн жагсаалтыг хэсэг тус бүрээр шалгахдаа орон нутгийн сонгуулиар 2024 оны 09 дугаар сарын 12-нд хэвлэгдсэн Сонгогчдын нэрийн жагсаалт болон иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгэгдсэн шилжин ирсэн, шилжин явсан бүртгэлийн мэдээлэл, нас барсан бүртгэлийн мэдээлэлтэй давхар тулган шалгав.

2.Баянхонгор аймгийн Баянлиг сумын 5-р баг Хатан суудал буюу 3-5-5 дугаар хэсэгт 4 хаяг шинээр нэмэгдэж орж ирснийг системд оруулав.

Сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотойгоор өөр ямар нэгэн асуудал, зөрчил одоогийн байдлаар гараагүй байна.

4.2.”Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл түр зогсоосонтой холбоотойгоор сонгуулийн программд хэсэг онолт хийж, шалгасан талаар”

“Иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг түр зогсоох тухай” Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн А/71 дугаарт тушаалын дагуу 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл түр зогссонтой холбоотойгоор шилжин ирсэн иргэдийг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн нөхөн сонгуулийн сонгогчийн нэрийн жагсаалтад хэсэг оноож баталгаажуулах, нягтлан шалгах ажлыг гүйцэтгэсэн талаар 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Илтгэх хуудсаар тайлагнасан бөгөөд тайлангаар хийгдсэн ажлын талаар товч тоймловол;

Үүнд:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн дараа буюу 2024 оны 10 дугаар сарын 12-ны өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 22-ныг дуусталх хугацаанд Аймгийн Иргэдийн хурлын төлөөлөгчийн нөхөн сонгууль явагдах Баянхонгор аймгийн Баянлиг суманд шилжин ирсэн 33 иргэн шилжилт хөдөлгөөний бүртгэл хийлгүүлсэн байх ба үүнээс 2 иргэн нь сонгуулийн насанд хүрээгүй, 5 иргэн e-mongolia.mn цахим системээр бүртгүүлсэн байна.

2. Шилжин ирсэн 33 иргэнийг сонгуулийн 3-5-1, 3-5-2, 3-5-3, 3-5-4, 3-5-5 дугаар хэсгүүдэд шилжин ирсэн хаягийг харъяаллаар нь харъяалагдах хэсэг тус бүрт хэсэг оноох ажлыг гүйцэтгэлээ. Тодруулбал, 3-5-1 хэсэгт 3, 3-5-2 хэсэгт 6, 3-5-3 хэсэгт 7, 3-5-4 хэсэгт 3, 3-5-5 хэсэгт 12 сонгогч хэсэг оноолт хийгдлээ.

3. Шилжилт хөдөлгөөний бүртгэл түр зогсоосонтой холбоотойгоор улсын бүртгэгчийн хөтөлдөг шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтэрт “Аймгийн Иргэдийн төлөөлөгчийн хурлын нөхөн сонгууль, “Иргэний шилжилт хөдөлгөөнийг түр зогсоох тухай” УБЕГ-ын даргын А/71 дугаар тушаалын дагуу 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 04 дүгээр сарын 22-ны хүртэлх хугацаанд 19 бүртгэл бүртгэсэн ба бүртгэлийг хаав” гэсэн хаалтын бичилтийг хийлгэж, тэмдэглэл хөтлөв. Мөн 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөртөө багтаан шилжилт хөдөлгөөний бүртгэлийг баталгаажуулж, нотлох баримтыг бүрэн цахимжуулж дуусгасан болно.

4.3 “Сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчид төлөв оноосон мэдээллийг шалгасан тухай”

Улсын бүртгэлийн сонгуулийн цахим системд оруулсан орон нутгийн нөхөн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтад Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6-д заасан эрх бүхий байгууллагын мэдээллийг үндэслэн Сонгогчдын нэрийн жагсаалтад “түр хасав” төлөвтэй бүртгэгдсэн сонгогчдын мэдээллийг шалгасан талаар тайлагнаж ажилласан.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6.3. Гадаадад 60 хоногоос дээш хугацаагаар зорчсон гэсэн үндэслэлээр “түр хасав” төлөвтэй **34 сонгогч**, 20.6.2. Хорих анги, эрүүгийн хэрэг, албадан эмчлүүлсэн гэсэн үндэслэлээр “түр хасав” төлөвтэй **1 сонгогч**, нийт **35 сонгогч “түр хасав” төлөвтэй** бүртгэгдсэн байв. Үүнээс;

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6.3. Гадаадад 60 хоногоос дээш хугацаагаар зорчсон гэсэн үндэслэлээр “түр хасав” төлөвтэй 35 сонгогчоос гадаад улсад суралцаж байгаа, энхийг сахиулах үүрэгт ажилд томилогдон ажиллаж байгаа,

ажиллаж амьдарч байгаа гэх зэрэг шалтгаанаар сонгуулийн санал авах өдөр ирж амжихгүй буюу “түр хасав” төлөв сэргээлгэх боломжгүй 23 сонгогч байна.

- Харин одоо сумдаа ажиллаж амьдарч байгаа буюу гадаад улсад огт зорчоогүй гэх **11 сонгогч** байгаагаас **5 сонгогчийн** өргөдлийг хүлээн авч, “түр хасав” төлөв сэргээсэн бүртгэлийг бүртгэв. Харин сонгогчдын нэрийн жагсаалтад “түр хасав” төлөвтэйгээр бүртгэлтэй 30 сонгогч үлдсэн болно.

4.4. “Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэж, хүлээлгэн өгсөн тухай”

Улсын бүртгэлийн сонгуулийн цахим системд оруулсан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны нөхөн сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, хэвлэсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг шалган баталгаажуулж, сонгуулийн хэсгийн хороодод хүлээлгэн өгсөн ажлын талаарх тайланг 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Илтгэх хуудсаар тайлагнасан бөгөөд тус тайланд дараах 2 ажлын хүрээнд тодорхой товч байдлаар тайлагнав. Үүнд:

1. Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, шалгах, баталгаажуулах ажлын талаар:

1.1. Хэлтсийн улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхамаар ахлуулсан ажлын хэсэг Баянхонгор аймгийн Баянлиг сумын 5 хэсгийн буюу 3-5-1, 3-5-2, 3-5-3, 3-5-4, 3-5-5 дугаар хэсгийн Сонгогчдын нэрийн жагсаалтыг улсын бүртгэлийн сонгуулийн программаас хэвлэх ажлыг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 12:00 цагт эхлэж, 13:00 цагт дуусгасны дараа хяналтын улсын байцаагч Л.Мэндбаяр, улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхам нар хуудас бүрээр нэг бүрчлэн тулган шалгасан ба сонгогчдын нэрийн жагсаалтыг шалгахад жагсаалтын хуудасны дугаарлалт болон сонгогчдыг дугаарласан дугаарлалт зөрсөн зэрэг алдаа гараагүй болно.

2. Сонгогчдын нэрийн жагсаалтыг хүлээлгэсэн өгсөн ажлын талаар:

Хэвлэгдэж, үйлдэгдэж, баталгаажсан сонгогчдын нэрийн жагсаалтыг улсын бүртгэгч /Баянлиг сумын/ С.Болор-эрдэнэ өөрийн биеэр гардан хүлээн авч, сумын сонгуулийн хорооны дарга, сонгуулийн хэсгийн хорооны дарга нарыг бүрэлдэхүүнээр нь бэлэн байлгаж 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 15:00 цагт хүлээлгэн өгөв.



ГУРАВ.УЛСЫН БҮРТГЭЛИЙН (ИРГЭНИЙ, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН, ЭД ХӨРӨНГИЙН) ҮЙЛЧИЛГЭЭГ ТҮРГЭН ШУУРХАЙ, ЧАНАРТАЙ ХҮРГЭХ

АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ;

Хэлтсийн хамт олон холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм журам, эрх зүйн бусад актууд болон байгууллагын үйлчилгээний стандартыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон иргэдэд түргэн шуурхай чирэгдэлгүй үйлчилж, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд баримтлан ажиллалаа.

Иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг чирэгдэлгүй, түргэн шуурхай хүргэх эрх зүйн орчин, орчин үеийн мэдээлэл технологийн шаардлагад нийцсэн цахим үйлчилгээг хүргэх нөхцөл боломж улам бүр төгөлдөршиж байгааг тэмдэглэхэд таатай байна.

3.1. ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Иргэний улсын бүртгэлийн тасгийн хамт олон Улсын бүртгэлийн багц хуулиуд, тэдгээртэй холбоотой бусад хууль, дүрэм, журмуудыг хэрэгжүүлж ажиллахын зэрэгцээ Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн үүрэг даалгавар, цаг үеийн ажлыг шуурхай хэрэгжүүлж, гүйцэтгэлийг хангах чиглэлээр 2025 оны эхний хагас жилд хийж хэрэгжүүлсэн, зохион байгуулсан ажлыг тайлагнаж байна.

Тайлант хугацаанд хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагааг голчлон хуулийн хэрэгжилт, хамтын ажиллагааг дэмжин ажиллах, сонгуулийн хуулиар улсын бүртгэлийн байгууллагын хүлээсэн чиг үүргийг амжилттай хэрэгжүүлэх, иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим санг цэгцлэх, улсын бүртгэлийн явуулын төхөөрөмжийг ашиглан явуулын үйлчилгээг үзүүлэх, алслагдсан сумын иргэдэд төрийн үйлчилгээг хүргэж төрийн үйлчилгээний хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, улсын бүртгэлийн анхан шатны нэгжид хүрээгүй улсын бүртгэлийн үйлчилгээг хүргэхэд гол анхаарлаа хандуулсан явдал нь энэ тайлангийн гол онцлог юм.

НЭГ. ЦАХИМ ШИЛЖИЛТ-ТООН ГАРЫН ҮСЭГ ОЛГОЛТ БОЛОН ТООН ГАРЫН ҮСГИЙН ХЭРЭГЛЭЭГ НЭМЭГДҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

1.1. Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд:

Монгол Улсын Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого” бодлогын баримтын бичгийн Зургаадугаар бүлгийн 6.1. Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулна. "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 6.1.1."Цахим үндэстэн" болох арга хэмжээг эрчимжүүлж, нийтийн мэдээллийн дэд бүтцийг боловсронгуй болгож, цаасан суурьтай үйл ажиллагааг багасган цахим харилцаанд шилжиж, нийтийн мэдээллийн системээс олж авах, солилцох боломжтой

мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх нөхцөлийг хангаж, цахимаар үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмж, тоог нэмэгдүүлж, иргэнийг цахим гарын үсгээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх” гэж төлөвлөсний дагуу Улсын бүртгэлийн Ерөнхий газраас Цахим гарын үсгийн тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан болон хэлтсийн зүгээс олон талт арга хэмжээг амжилттай хэрэгжүүллээ. УБЕГ-аас Тоон гарын үсэг олголтыг идэвхижүүлэх, нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2023 онд ХААН банкт хамтран ажиллах санамж бичиг байгуулж, санамж бичгийн дагуу “Тоон гарын үсэг олголтыг идэвхижүүлэх аян”-г зохион байгуулсан аяны хүрээнд улсын бүртгэгч нар **13885** тоон гарын үсэг олголтыг хийсэн амжилтаар тэргүүлсэн билээ. 2023 онд ийнхүү тоон гарын үсгийн олголтыг чухалчилсан бол 2024, 2025 онуудад тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, тоон гарын үсэг хэрэглэх чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

1. Тоон гарын үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, тоон гарын үсгээ хэрэглэж хэвшүүлэхэд чиглэсэн мэдээлэл өгөх, гар утасны апплейкшнээ ашиглан хэрхэн хэрэглэх, улсын бүртгэлийн хичнээн төрлийн үйлчилгээг **E-Mongolia, E-Business** цахим платформаас тоон гарын үсэг ашиглан төрийн цахим үйлчилгээ авах, цахим ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга зүйн сургалтыг 2025 оны 02 дугаар сараас эхлэн зохион байгууллаа.


2. 2025 онд 2024 онд анх бэлтгэгдсэн “Цахим элч” болсон сургуулийн ахлах ангийн сурагчдын тоог нэмэгдүүлэх, сум болгонд “Цахим элч-Цахим сургагч багш” нарыг бэлтгэх, мөн хуулийн хэрэгжилт, хамтын ажиллагааг дэмжих, цахим үндэстэн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд 2025 оны 02 дугаар сарын 23-нд танхимаар 56, зүүмээр 110 хүүхэд, нийт 165 хүүхдийг хамруулан “Цахим элч-цахим сургагч багш” бэлтгэх сургалтыг зохион байгуулав.

3. “Цахим элч-цахим сургагч багш” хүүхдүүдийг байнга хөгжүүлэх, сургаж тэд нараар дамжуулан нийгэм олон нийтэд нөлөөллөх нөлөөллийн ажлыг үр



дүнтэй зохион байгуулахад чиглэгдсэн арга хэмжээнүүд авч хэрэгжүүлж байна. Үүнд:

Баянхонгор аймгийн Ахмадын холбоо, Баянхонгор сумын ахмадын хороо, Баянхонгор аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбоо, Тэргэнцэртэй иргэдийн холбоо, Хараагүй иргэдийн холбоо зэрэг олон нийтийн байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлж, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн цахим ур чадварыг сайжруулах, тоон гарын үсгийн хэрэглээний чадварыг эзэмшүүлэхэд чиглэсэн нөлөөллийн сургалтыг 2025 оны 5 сард “Цахим элч-цахим сургагч багш” хүүхдийн оролцоотойгоор тоон гарын үсгийн болон, И-монголио цахим системийн апп утсан дээр нь суулгаж, тоон гарын үсэг олгох ажлыг амжилттай зохион байгуулав.



Ийнхүү өсвөр үеийн 200 хүүхэд, ахмад 45, хөгжлийн бэрхшээлтэй 18 иргэдийн бүрэхдэхүүнтэй бүлгэмийг бий болгож, улмаар тогтвортой, байнгын үйл ажиллагаатай клубыг байгуулж, иргэдийн цахим ур чадварыг сайжруулах зорилтод арга хэмжээтэй уялдуулан аймгийн Төрийн цахим үйлчилгээний хэлтэс, Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран өсвөр үеийн, ахмадын болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн “Хурдан-24/7” клубыг аймгийн Засаг даргын дэргэдэх клубын зохион байгуулалттайгаар байгуулав. Өсвөр үеийн 165 хүүхэд, ахмадын 45, хөгжлийн бэрхшээлтэй 18 иргэдийг клубын гишүүнээр элсүүлж, төрийн цахим үйлчилгээг авах арга зүйн сургалтуудыг зохион байгуулж, цахим ур чадварыг нэмэгдүүлэв.



Өсвөр үеийн “Хурдан-24/7” клубын нээлтийн арга хэмжээнд аймгийн төвийн ерөнхий боловсролын сургуулийн болон Баян-овоо, Эрдэнэцогт, Өлзийт, Баянхонгор сумын Шаргалжуут багийн сургуулийн 115 хүүхэд танхимаар, хөдөөгийн 16 сумын сургуулийн 85 хүүхэд цахимаар, мөн сум бүрийн “Хурдан-24/7” клубын чиглүүлэгч болоод дэмжлэгийн баг болох Насан туршийн суралцахуйн нэгжийн багш нар, сумдын улсын бүртгэгч нар, и-монголиа хариуцсан операторууд болон аймгийн Засаг даргын орлогч Б.Наранбаяр, ТЦҮЗГ-ын Сургалт, хөгжлийн хэлтсийн дарга Г.Ариунзаяа, Баянхонгор аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн дарга Д.Амгалан, Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Ц.Мөнхжаргал, аймгийн Засаг даргын удирдлагын багийн мэдээллийн технологи хариуцсан гишүүн Г.Ганчулуун нар оролцож, өргөн цар хүрээний томоохон ажлыг нэг боллоо.

Арга хэмжээний үеэр “Хурдан-24/7” клубыг санаачлан үүсгэн байгуулагчийн нэг Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга П.Бүжинлхам “Хурдан-24/7” клубын зорилго, чиглэл, цаашдын үйл ажиллагааны талаар танилцуулга хийсэн бол “Цахим элч” сургагч багш хүүхдийн төлөөлөл, Номгон ахлах сургуулийн 11а ангийн сурагч М.Өлзийжаргал, Эрдэнэмандал сургууль 10в ангийн сурагч Д.Мөнх-Оргил клубт хамрагдаж, цахим боловсролын ач холбогдлын талаар өөрсдийн туршлага, сэтгэгдлээ хуваалцсан нь иргэд олон нийтийн цахим хэрэглээг нэмэгдүүлэхэд маш чухал нөлөөллийн ажил болсон билээ.

Энэ тухай тайлан, мэдээг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын фэйж хуудас, “Нээлттэй засаг-нэг Баянхонгор”, “Баянхонгор Хурдан-24/7” клуб фэйж хуудсаар тус тус мэдээллэгдсэн тул эдгээр фэйж хуудаснаас дэлгэрэнгүй мэдээлэл авах боломжтой юм.

1.2. Тоон гарын үсгийн олголтын талаарх тоон мэдээг харуулбал:

2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 10-ны хооронд Тоон гарын үсгийн олголт киоск машинаас гар утсанд 1025, иргэний үнэмлэхэнд 1293, нийт 2318 тоон гарын үсэг олгогдсон бол, харин улсын бүртгэгчээс гар утсанд 3654, иргэний үнэмлэхэнд 34, нийт 3688 тоон гарын үсэг олгогдсон байна. өөрөөр хэлбэл, киоск болон улсын бүртгэгчээс нийт 6006 тоон гарын үсэг олгогдсон байна.


Харин нэгжээс 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 12-ныг өдрийг дуусталх хугацаанд 6956 тоон гарын үсэг олгогдсон байна.

Мөн улсын бүртгэлийн киоск машинаас иргэний улсын бүртгэлийн 1964 лавлагаа олгогдсон байна.

ХОЁР. ЦАХИМ ШИЛЖИЛТ- ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЦАХИМ САНГ ЦЭГЦЛЭХ АЖЛЫН ЧИГЛЭЛЭЭР


2.1. Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим сангийн талбарын мэдээллийн зөрүүтэй мэдээллийг арилгах, цэгцлэх ажлын хүрээнд:

2.1.1. Иргэний улсын бүртгэлийн эцэг эхийн нэр, регистрийн дугаарыг ХААТР-11 маягтад буруу бичигдсэний улмаас цахим санд төрсний бүртгэлд эцэг, эхийн мэдээлэл ороогүй, овог нэр өөрчлөлтийн болон эцэг /эх/ тогтоолтын бүртгэлд өмнөх мэдээлэл ороогүй, төрсний бүртгэл “алдаатай” төлөвтэй, гэрлэсний бүртгэл цахим санд ороогүй, үндсэн санд гэрлэлтийн мэдээлэл буруу орсон, иргэний төлөв буруу орсон гэх мэт цахим санд алдаатай, зөрүүтэй орсон зөрчлийг арилгасан, арилгаж буй талаар:



2.2. Цахим архивын баяжилтыг хийх чиглэлээр:

2.2.1. Нэг талаас цахим архивын баяжилтыг хийх, нөгөө талаас архивын ажилтны ажлын ачааллыг бууруулах зорилгоор Баянхонгор аймгийн 2007-2021 онуудад төрсөн иргэдийн ХААТР-11, ХААТР-13, ХААТР-14 маягтуудыг цахимжуулах ажлыг 2024 онд эхлүүлсэн ба 2025 оны 02 дугаар сардаа багтаан үлдсэн Баянхонгор сумын 2014-2021 оны, Шинэжинст сумын 2015-2021 оны маягтуудыг бүрэн цахимжуулж дуусгалаа.



2.2.2. Мөн Иргэний улсын бүртгэлийн мэдээлэл лавлах системд цахимжаагүй 1963-1998 оны ХААТР-15-ыг цахимжуулах, иргэний улсын бүртгэлийн цахим санд бүртгэгдээгүй гэрлэлтийн бүртгэлийг нөхөн оруулах ажлыг тасгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 2025 ондоо багтаан хийхээр төлөвлөсөн болно.

2.2.3. Иргэний улсын бүртгэлийн нөхөн бүртгэл, нэмэлт өөрчлөлтийн бүртгэл хийлгүүлэхээр ирүүлсэн 252 өргөдөл, хүсэлтээс өнөөдрийн байдлаар 215 өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэсэн байх бөгөөд шийдвэрлэсэн өргөдөлтэй холбоотойгоор төрсний, гэрлэсний, үрчилсний бүртгэлийн **183 хуудас нотлох баримт**, маягыг “Мэдээлэл лавлах” системд цахимжуулсан байна.

ГУРАВ. УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЯВУУЛЫН ҮЙЛЧИЛГЭЭГ ҮЗҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР

3.1. Алслагдсан сум, багийн иргэдэд улсын бүртгэлийн үйлчилгээг хүргэх ажлын хүрээнд:

3.1.1. Анхан шатны нэгжид болон зорилтод бүлэгт улсын бүртгэлийн явуулын төхөөрөмжийг ашиглан улсын бүртгэлийн үйлчилгээг газар дээр нь хүргэж, үйлчилгээний хүртээмжтэй, шуурхай байдлыг нэмэгдүүлэх, хуулийн хэрэгжилт, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилтыг хангах арга хэмжээний хүрээнд **“Улсын бүртгэлийн явуулын үйлчилгээ үзүүлэх өдөрлөг”-ийг “Иргэнд ойрхон төрийн үйлчилгээ”** уриатайгаар сумуудад ажиллахдаа засаг захиргааны анхан шатны нэгж сумын ЗДТГ-ууд болон төрийн бусад байгууллагуудтай хамтран ажиллалаа. Тодруулбал,

- УБЕГ-ын болон Хэлтсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан анхан шатны нэгжид болон зорилтод бүлэгт улсын бүртгэлийн явуулын төхөөрөмжийг ашиглан улсын бүртгэлийн үйлчилгээг газар дээр нь хүргэж, үйлчилгээний

хүртээмжтэй, шуурхай байдлыг нэмэгдүүлэх зорилтыг хангах арга хэмжээний хүрээнд Жинст, Богд сумын иргэдэд үндэсний энгийн гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээ, иргэний улсын бүртгэлийн хууль, журам зөрчсөн иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлж, бүртгэлийн үйлчилгээний “нэг цэг”-ийн үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг 2025 оны 01 дүгээр сарын 21-23-ны өдрүүдэд Жинст, Богд сумдад зохион байгуулж, 102 иргэнд гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээ үзүүллээ. Мөн улсын бүртгэлийн журам зөрчсөн буюу хуулийн хугацаа хэтрүүлсэн 3 иргэний үйлдэлд зөрчлийн хэрэг үүсгэн зөрчлийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хийгдсэн байна.

- Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 104 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, иргэд олон нийтэд хууль тогтоомж сурталчлах, өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, үйл ажиллагааг таниулахад чиглэгдсэн “Нээлттэй хаалганы өдөрлөг” арга хэмжээг зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 11-ны өдрийн 13 дугаарт удирдамжийн дагуу оролцож, төрийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах зорилтод арга хэмжээг хэрэгжүүлэв. Тус арга хэмжээнд оролцсоноор 5 иргэнд тоон гарын үсэг олгох, 1 иргэнд гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээ үзүүллээ.

- Шинээр батлагдан гарсан хууль тогтоомжийг сурталчлах, төрийн болон хууль сахиулах байгууллагуудын үйл ажиллагаа, мэдээ, мэдээллийг танилцуулах, иргэдийн өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, зөвлөгөө мэдээлэл өгөх, тэдгээрт төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх, төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд зөвлөн туслахад чиглэгдсэн “Хууль, сурталчлах, зөвлөн туслах, сургалт нөлөөлөл”-ийн арга хэмжээ зохион байгуулах тухай” аймгийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 32 дугаарт удирдамжийн дагуу аймгийн хуулийн байгууллага (Хууль эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар, Прокурорын газар, Шүүх шинжилгээний газар, гэх мэт)-уудтай хамтран оролцов.



Тус арга хэмжээнд оролцохдоо улсын бүртгэлийн цахим шилжилтийн өнөөгийн байдал, цахимаар үзүүлж байгаа үйлчилгээний танилцуулгыг хийх, сумын улсын бүртгэгч бүрийн оролцоог бий болгож, тэдний илтгэх чадварыг сайжруулах зорилгоор улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхам Баянбулаг, Бууцагаан, Хүрээмарал сумдын улсын бүртгэгч нарт персантаци бэлтгэн өгч, цахим зүүмээр сургалт зохион байгуулж, мэргэжлийн арга зүйгээр ханган чиглүүлж ажиллалаа. Мөн улсын

бүртгэгч томилогдоогүй Бөмбөгөр суманд улсын ахлах бүртгэгч П.Бүжинлхамаар ахлуулсан ажлыг хэсэг буюу улсын бүртгэгч З.Дуламсүрэн, Т.Мягмарсүрэн, мэдээлэл технологийн мэргэжилтэн Р.Доржнямбуу нар ажиллаж, 7 иргэнд иргэний улсын бүртгэлийн, 8 иргэнд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэн, бүртгэлтэй холбоотой зөвлөгөөг 13 иргэнд өгөв.

3.2. Зорилтод бүлгийн иргэдэд улсын бүртгэлийн явуулын үйлчилгээ үзүүлэх ажлын хүрээнд:

- Тайлант хугацаанд хөгжлийн бэрхшээлтэй 35 иргэнд иргэний улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлсэн байх ба үүнээс өндөр настай хөгжлийн бэрхшээлтэй 6 иргэнд 4G төхөөрөмжөөр явуулын үйлчилгээг гэрээр нь очиж иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж, бичиг баримттай болголоо.
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс гадна хэвтрийн дэглэмтэй, эмнэлэгт хүүхдээ харан хэвтэж буй ээжүүд, өндөр настай ахмадууд зэрэг зорилтод бүлгийн иргэдэд болон аймгийн төвийн алслагдсан баг болох Шаргалжуут багийн иргэдэд явуулын үйлчилгээг үзүүлсэн байна. Үүнд, иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэл 16, иргэний бүртгэлийн лавлагаа 8, төрсний бүртгэл, төрсний гэрчилгээ олголт 3, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл 7, иргэний үнэмлэхний дахин 3, иргэний үнэмлэх олголт 1, овог нэр өөрчлөлтийн бүртгэл 1, эцэг тогтоолтын бүртгэл 2, гэрлэсний бүртгэл 2, гэрлэлт дуусгавар болсны бүртгэл 1, тоон гарын үсэг олголт 44, гадаад паспортын бүртгэл 2 нийт 90 бүртгэл хийсэн байна.

4.Бусад арга хэмжээний хүрээнд:


4.1. Улсын бүртгэгч нарыг мэргэжлийн арга зүйгээр хангаж ажилласан талаар:

- Иргэний улсын бүртгэлийн газраас ирүүлсэн 2025 оны 3/432, 3/1017 дугаарт чиглэл, зөвлөмж болон бусад чиглэл зөвлөмж бүрийг цаг тухай бүрт нь улсын бүртгэгч нартаа дамжуулан мэдээллэж, арга зүйгээр ханган ажиллаж байна. Мөн төрсний бүртгэлийг бүртгэхдээ нэрийн толийг бүрэн дүүрэн ашиглах, нэрийг сонгохдоо нэрийн галигийг давхар харж хянаж байж нэрийг сонгох талаар өдөр тутамдаа зөвлөгөө өгч, гарсан алдаа бүрийг даруй засуулсны дараа баталгаажилтыг хийж байна. Мөн төрсний бүртгэл, эцэг тогтоосны бүртгэл, овог нэр өөрчлөлтийн бүртгэлийн баталгаажуулалтыг хийхдээ эцэг эхийн мэдээлэл зөрүүтэй, цахим санд овог нэр өөрчилсний бүртгэл болон эцэг эх тогтоосны бүртгэлийн өмнөх мэдээлэл ороогүйн улмаас дараагийн бүртгэл хийх боломжгүй, мөн 16 нас хүрч иргэний үнэмлэх анх удаа авч буй иргэний ургийн овог ороогүй,

ургийн овгийн бичвэр зөрсөн, эцэг эхийн мэдээлэл цахим санд дутуу бөгөөд буруу орсон зэрэг тохиолдолд хамаарал бүхий иргэний өргөдлийг авч цахим санд засвар, нэмэлт өөрчлөлтийг бүртгэх ажиллагааг давхар хийж байна.

- Баянхонгор аймгийн сумдын бүх багуудад багийн иргэдийн нийтийн хурал хуралдах, багийн Иргэдийн нийтийн хурлын дарга, Засаг дарга нарыг сонгох сонгуульт ажил явагдаж байгаатай холбоотойгоор хэсэг бүлгийн зохион байгуулалттайгаар хомроглон иргэдийг уриалан, ухуулж ятган хийж буй үйлдэл биш байгаа гэх хардлагыг төрүүлж байна. Иймд сумаас сумд, багаас багт шилжсэн шилжилт хөдөлгөөний бүртгэлтэй холбогдуулан хууль тогтоомжийн үзэл санаа, зорилго нь шилжин суурьшигчдын орох, гарах хөдөлгөөнийг зөв зохистой удирдах, зохицуулах, хязгаарлах бодлогын арга хэрэгслийн хүрээнд 180 хоног ба түүнээс дээш хугацаагаар шилжин суурьших бол улсын бүртгэлд бүртгүүлэх, харин 180 хоног ба түүнээс доош хугацаагаар шилжин суурьших бол баг, хорооны Засаг даргад бүртгүүлэх зохицуулалтыг хуульчилж өгсөн байх ба 180 хоногоос дээш хугацаагаар шилжин суурьшихаар бүртгүүлсэн иргэнийг байнгын оршин суугч гэж тодорхойлсон зэрэгт эрх зүйн бодитой, үнэн зөв дүгнэлт хийж, байнгын оршин суугч, түр оршин суугч гэдгийн ялгаа, хууль зүйн үр дагавар, агуулгыг бүрэн ойлгож шилжилт хөдөлгөөний бүртгэл хөтлөхийг зөвлөж, анхаарах асуудлын талаар хэд хэдэн чиглэлийг өгч, улсын бүртгэл бүртгэх үйл ажиллагаатай холбоотойгоор бүртгэх, эс бүртгэх шийдвэр нь өөрөө Захиргааны байгууллагын шийдвэр буюу захиргааны эрх зүйн акт мөн тул Захиргааны ерөнхий хуулийн 24, 25, 26, 27 дугаар зүйлд заасан хуулийн хэм хэмжээг хуулийн хүрээнд зөв хэрэглэж шийдвэрээ гаргахыг чухалчлан анхааруулж, аливаа гарч болох эрсдлээс урьдчилан сэргийлж ажиллав. Мөн шилжилт хөдөлгөөний бүртгэлийг бүртгэхэд анхаарах асуудлын талаар хяналтын улсын байцаагчтай хамтран арга зүйн сургалтыг 2 удаа зохион байгуулсан, мөн албан бичгээр 2 удаа чиглэл, хэлтсийн ажилтнуудын хаалттай facebook группээр 2 удаагийн чиглэлийг өгч, мэргэжил арга зүйгээр хангаж, арга зүйн туслалцаа үзүүлэв.



- Иргэний улсын бүртгэл хөтлөхөд анхаарах асуудал, бүртгэлийн эх нотлох баримтыг үнэлэх, хуулийг зөв ойлгож хэрэглэх, бүртгэлийн гарч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр улсын бүртгэгч нарт танхимын болон



цахим, хосолсон 6 удаагийн сургалтыг “Бүртгэлийн эрсдлээс урьдчилан сэргийлэх, нотлох баримтыг үнэлэхдээ анхаарах асуудал”, “Гэр бүлийн эрх зүйн харилцаа, гэр бүлийн байдлын бүртгэл хөтлөх, анхаарах асуудал”, “Нас барсны бүртгэл, үрчлэлтийн бүртгэл, түүнийг бүртгэхэд анхаарах асуудал” зэрэг олон талт сэдвээр орлоо.



- Иргэний улсын бүртгэлийн газраас иргэний үнэмлэхийн бүртгэл шалгахад Монгол Улсын 25, 45 нас хүрсэн иргэн иргэний үнэмлэхийг солиулахаар биеийн давхцахгүй өгөгдлийн /гарын хурууны хээ/ бүртгэлд бүртгүүлэхэд улсын бүртгэгч “сунгалт” гэсэн төлөвийг сонгохгүйгээр “дахин” гэсэн сонголтыг сонгосноос шалтгаалж, иргэний бүртгэлийн бүртгэлийн мэдээллийн санд зөрчилтэй мэдээлэл бүртгэгдэж, улсын бүртгэлийн байгууллагаас олгодог баримт бичиг алдаатай гарсан зөрчил илэрсэн талаар “Иргэний үнэмлэхийн бүртгэл шалгах тухай” Иргэний улсын бүртгэлийн газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 3/432 дугаарт албан бичгээр ирүүлсэн мэдэгдэл, чиглэл, үүрэг даалгаврын хэргжилтийг хангах арга хэмжээний хүрээнд 2024 оны 12 дугаар сарын 10-наас 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр хүртэлх хугацаанд бүртгэгдсэн иргэний үнэмлэхийн бүртгэлийг шалгаад “...Иргэний улсын бүртгэлийн газар болон хэлтсээс шалгаад улсын бүртгэгчийн буруутай үйлдлээс гарсан бүртгэлийн зөрчил, алдааг арилгуулах, хохирлыг барагдуулах талаар



тухай бүрт нь арга хэмжээ авч байхаар чиглэл өгөгдөөд байгаа тул улсын бүртгэгч бүр бүртгэлийн үйл ажиллагаандаа сайтар нягт нямбай анхаарч ажиллах, хэрэв алдаа, зөрчил давтан гаргавал дараагийн шатны арга хэмжээ авагдах нөхцөл болно гэдгийг Хэлтсийн даргын 2025 оны 13/65 дугаарт албан бичгээр мэдэгдэж, тодорхой чиглэл, зөвлөмж, анхааруулгыг өгөхийн зэрэгцээ зөрчил гаргасан 2 албан хаагчид хэлтсийн даргын албан бичгээр Албан шаардлага хүргүүлж, зөрчил дахин давтагдаж гарах эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч, авч хэргжүүлсэн арга хэмжээний ажлын тайланг Илтгэх хуудсаар Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлсэн болно.

- Улсын бүртгэгч нарыг улс төрийн дарамт, ажлын байрны дарамтаас урьдчилан сэргийлэх болон улс төрийн нөлөөлөөс хамгаалах зорилгоор Аймаг,

үрчилсний бүртгэлийн **183 хуудас нотлох баримт**, маягтыг “Мэдээлэл лавлах” системд цахимжуулсан байна.


4.2.2.Хэлтсийн bayankhongor@burtgel.hov.mn мэйл хаяг болон бичгээр, мөн Засгийн газрын 11-11-ээр дамжин ирүүлсэн нийт 13 өргөдөл гомдлоос 12 өргөдөл гомдлыг хуулийн хугацаанаас өмнө шуурхай шийдвэрлэж, өргөдлийг хариуг хэлтсийн даргын гарын үсэгтэй албан бичгээр өгсөн ба судлагдаж байгаа 1 өргөдөл байна.

5. Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээний тоон мэдээ:


Иргэний улсын бүртгэлийн тоон мэдээг харуулбал:



■ өөрчлөлтийн бүртгэл



Шинээр олгосон иргэний үнэмлэх, биеийн давхцахгүй өгөгдлийн бүртгэл



ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

Хуулийн этгээд эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга, улсын ахлах бүртгэгч болон улсын бүртгэгчид нь Монгол улсын Үндсэн хууль Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний Улсын бүртгэлийн тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Архивын тухай хууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Иргэний улсын бүртгэл хөтлөх журам, болон холбогдох бусад дүрэм журам чиглэлийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон Иргэний эрхийг бүрэн ханган ажиллаж байна.

Тайлант хугацаанд Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

НЭГ:ЕРӨНХИЙ ГАЗРААС БОЛОН УДИРДЛАГААС ӨГСӨН ЧИГЛЭЛ,
ЗӨВЛӨМЖ, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ТАЛААР:

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Тамгын газрын эрх зүйн хэлтсээс 2024 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн 2-1/12503 тоот албан бичиг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн А/167 дугаарт тушаалын хэрэгжилтийн талаар:

Ипотек болон /Барьцаа/-ийн бүртгэлийн үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд ажлын нэг өдөр буюу мэдүүлэг гаргасан даруйд нь нийт 1919 бүртгэлийг бүртгэн баталгаажуулсан байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 5/15140 тоот албан бичгийн биелэлтийн талаар:

Тус албан бичигт дурьдагдсан Богд банкны эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга тэмдгийн дардас бүхий тус банкны барьцаанд байгаа үл хөдлөх эд хөрөнгийг чөлөөлөх, өмчлөх эрхийг шилжүүлэх албан бичгийг үндэслэн эрхийн улсын бүртгэлийг хөтлөн ажиллах тухай мэдэгдлийг улсын бүртгэгч нарт танилцуулсаны дагуу үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд дээрх бүртгэлийн үйлчилгээг авахаар Баянхонгор аймгийн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасагт мэдүүлэг гаргаагүй байна.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 1/16192 дугаарт албан бичгээр ирүүлсэн зөвлөмжийн биелэлтийн талаар:

Эрхийн улсын бүртгэлд урьдчилсан тэмдэглэл хийх, урьдчилсан тэмдэглэлийг дуусгавар болгох, хүчингүй болгох, нийтийн зориулалттай орон сууцны зориулалтыг өөрчлөх, шүүх арбитрын шийдвэрийн үндсэн дээр өмчлөгч өөрчлөгдөх бүртгэлүүдийг үнэн зөв бүртгэх талаар ирүүлсэн зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 5/529 тоот албан бичгийн биелэлтийн талаар:

Хяналт шалгалтын газрын хяналтын улсын ахлах байцаагчийн 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 01 дүгээр мэдэгдлийг улсын бүртгэгч нарт танилцуулсны дагуу үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 1/2058 дугаарт албан бичгийн хэрэгжилтийн талаар:

Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга нь Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтад зааснаар “Улсын бүртгэлийн байгууллагын үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах”, 17.1.3 дахь заалтад “Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээний стандартыг мөрдүүлэх” эрхтэй гэж заасан бөгөөд мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Улсын бүртгэлийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална” гээд 4.1.1 дэх заалтад “Нэгдмэл тогтолцоо, арга зүйтэй байх”, гэж заасны дагуу ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Тамгын газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 6 дугаарт албан бичгийн хэрэгжилтийн талаар:

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн А/19 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс Улсын бүртгэлийн Ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулан ажиллаж байгаатай холбогдуулан дараах саналуудыг өгсөн. Үүнд:

Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.9-г хасах

Цахимаар бүртгэдэг болох талаар нэмж оруулах

Хуулийн 18 дугаар зүйлийн 18.7.7 дээр Эд хөрөнгийн эрхийн улсны бүртгэлийн гэрчилгээ хаяж үрэгдүүлсэн, үл хөдлөх эд хөрөнгийг нэгтгэсэн мөн хувийн хэргийг хаах тохиолдолд хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр, мөн бүртгэгч өөрөө бүртгэх эрхийг хуульчилж өгөх /Тухайн орон нутагтаа үл хөдлөх эд хөрөнгийг газар дээр нь очиж нятлаж шалгах боломжтой/

Хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дээр эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэгч нарыг эрх зүйч мэргэжилтэй бөгөөд хуульчийн сонгон шалгаруулалтад орох эрхийг нь тусгаж өгөх /жич: эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэгч нар нь эрх зүйн дүгнэлт хийдэг, шүүх хурал болон зөрчил маргаанд бүртгэлийн

байгууллагыг төлөөлж оролцдог гэх мэт хуульчийн байр суурьнаас хандах асуудал их байдагтай холбоотой хуульчийн сонгон шалгаруулалтад орох эрхтэй болмоор байна./саналуудыг 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр e.battsengel@burtgel.gov.mn хаягаар хүргүүлсэн.

Хууль зүй, дотоод хэргийн яамны 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 3/174 дугаарт албан бичиг, Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Тамгын газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 2/4463 дугаарт албан бичиг, Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Тамгын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн 2/6671 дугаарт албан бичгийн хэрэгжилтийн талаар:

УБЕГ-ын Тамгын газрын 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 2/6671 дугаарт албан бичгийн дагуу Жендэрийн үндэсний хороо, хууль зүй, дотоод хэргийн яамны Жендэрийн салбар зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөг үндэслэн хэлтсийн 2025 оны жендэрийн төлөвлөгөөний биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр хэлтсийн бичиг хэргээр дамжуулан /khandsuren.v@burtgel.gov.mn/ хаягаар хүргүүлж ажилласан.

Улсын бүртгэлийн Ерөнхий газрын Тамгын газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 17 дугаартай дотоод албан бичгийн хэрэгжилтийн талаар:

УБЕГ-ын 2025.03.19-ний өдрийн 17 дугаартай дотоод албан бичгээр ирүүлсэн улсын бүртгэл хөтлөх болон албан хэрэгцээнд цаасны хэрэглээ бууруулах талаар дараах саналуудыг 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр naranchimeg.a@burtgel.gov.mn хаягаар хүргүүллээ. Үүнд:

Бүртгэл боловсруулалт хийсний дараа хэвлэгддэг А,В хуудсыг хэвлэгддэггүй эсвэл иргэнд очих хэсгийг өгөхгүй зөвхөн нотлох баримтад А5 хэмжээгээр хэвлэгддэг болох

Иргэдээс ирж байгаа нотлох баримтыг авахдаа өргөдөл бичих цаас болон нотлох баримтыг олшруулж канондах ажлыг иргэдээр өөрсдөөр нь бүрдүүлж авдаг байх

Тайлан, мэдээ, төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтүүдийг цахим болгож цаасаар хэвлэж авдаггүй байх

Хуулийн этгээдийн бүртгэл дээр бүртгэх шийдвэрийг бүртгэл боловсруулан гэрчилгээ хэвлэж иргэнд олгосны дараа хэвлэж архивладаг нь ач холбогдолгүй цаас үрсэн процесс юм.

Албан бичгийн хариу хүргүүлэхдээ төслөө цахимаар хүргүүлдэг байх

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах талаар дараах саналуудыг хүргүүлсэн. Үүнд:

1.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 5.3.-д оруулах санал: - “....бүртгэснийг нотолж эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ олгоно” үүнд цахимаар бүртгэл хийхтэй холбоотойбүртгэснийг нотолж бар код бүхий, тоон гарын үсгээр баталгаажсан (гэх мэт) гэрчилгээг мөн олгоно” гэж;

2. Хуулийн 5.6-д “Гэрчилгээг хаяж үрэгдүүлсэн бол өмчлөгчийн нотариатаар гэрчлүүлсэн өргөдөл гэж өөрчлөлт оруулах. Хуульд хаяж үрэгдүүлсэн тухай өргөдлийг нотариатаар гэрчлүүлэхийг хуульчлаагүй боловч практик дээр нотариатаар гэрчлүүлэн авч бүртгэл хөтөлж байна. (хуулийн 7.8-д хуульд заасан бол мэдүүлэгт хавсаргах баримт бичгийг нотариатаар гэрчлүүлсэн байна гэж заасан. Гэтэл хуульд заагаагүй байхад чиглэлийн дагуу нотариатаар гэрчлүүлэн авч байгаа.)

Мөн хүчингүйд тооцуулах тухай өдөр тутмын сонинд зарлуулсан зарыг үндэслэн улсын байцаагчийн шийдвэрээр гэрчилгээг хүчингүйд тооцож, улсын бүртгэгч ажлын 15 өдрийн дотор дахин олгоно гэснийг хасаж, хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн улсын бүртгэгч шийдвэрлэх эрхийг хуульчилж өгөх, хугацааг ажлын 5 өдрийн дотор дахин олгоно гэж өөрчлөлт оруулах;

“Өдөр тутмын сонинд зарлуулсан зар”-ыг өнөөгийн цахим хөгжилтэй нийцүүлэн төрийн байгууллагуудын нэгдсэн эсвэл өөрийн байгууллагын “хүчингүйд тооцож нийтэд мэдээлэх” чиглэл бүхий сайттай болж тухайн сайтад иргэн мэдээлэлээ байршуулдаг байх гэх мэтээр цахим хөгжил, цахим мэдээллийн орчинтой нийцүүлэх;

хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэн тухайн орон нутаг дүүрэгтээ улсын бүртгэгч шийдвэрлэдэг байхыг хуульчилж өгөх. Ингэснээр иргэд УБЕГ-ын даргын тушаалыг хүлээн цаг хугацаа алдахгүйгээр бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай авах нөхцөл бүрдэнэ. /УБЕГ-ын даргын 2023 оны 08 дугаар сарын 24-ний А/1614 дугаарт тушаал/

3.Хуулийн 5 дугаар зүйлийн 5.8-д заасан хуулийн хугацааг ажлын 5 өдөр гэж өөрчлөх;

4.Хуулийн 7-р зүйлд:Нэг мэдүүлгээр 2 болон түүнээс дээш бүртгэлийг хийлгэхээр мэдүүлэг гаргаж болохыг хуулинд оруулж санд үндсэн бүртгэлийн төрлийг сонгоод давхар хийлгэх бүртгэлийг дэд төрлөөр сонгон бүртгэдэг, лавлагаа энэ төрлөөр гардаг болно.

5.Хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1.-д хувийн сууц, авто граж гэх мэтийг бүртгэхэд үнийг хэрхэн тодорхойлох талаар хуульчлаагүй. Үүн дээр өмчлөгчийн өөрийнх нь тодорхойлсон үнийг тусгадаг байхаар нэмэлт оруулах;

6.Хуулийн 10.3-дөмчлөх эрхийг анх удаа бүртгэхэд дараах нотлох баримтыг бүрдүүлэх, бүрдүүлсэн нотлох баримтад дараах мэдээллүүд туссан байна гэж өөрчлөх;

7.Хуулийн 10.3.1.-д “газрын эрх олгосон шийдвэрийн он, сар, өдөр, дугаар, хугацаа” гэж, 10.3.3-д газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны дүгнэлт, 10.3.4.-дашиглалтад орсон он сар өдөр, 10.4-дтус бүрд ногдох хувийг, 11.1.4.-дэх заалтыг бүртгэлд тусгахаар хуульчилсан боловч өнөөдрийн байдлаар эдгээр заалт хэрэгждэггүй буюу мэдүүлэг хүлээн авах, боловсруулах шатанд тухайн мэдээллийг тусган бүртгэдэггүй болно. (мэдээллийн сангийн хөгжүүлэлт дээр оруулж өгөх)

8.Хуулийн 14.1.-д.....нотариатаар гэрчлүүлсэн өргөдөл гэж нэмэлт оруулж тус бүртгэлийг улсын бүртгэгч шийдвэрлэдэг байхаар;

9.Хуулийн 14.1.5-д заасныг хяналтын улсын байцаагчийн шийдвэрээр улсын бүртгэгч хааж бүртгэхээр нэмэлт өөрчлөлт оруулах;

10.Хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д зээлдэгч, хамтран зээлдэгч мэдүүлэг гаргаж болохоор өөрчлөлт оруулах.

11. хуульд нэмэлтээр *өмчлөх эрхээ бусдад шилжүүлсэн анхны өмчлөгч өөртөйгөө холбоотой анхны бүртгэлийн нотлох баримтын хуулбарыг авч байгаа тохиолдолд мэдүүлэг* гаргаж болдог байх

12. хуульд нэмэлтээр *үл хөдлөх эд хөрөнгийн анхны бүртгэлийг бүртгэн баталгаажуулахад газрын төлөв хянан баталгааны дүгнэлт* авдаггүй байх хасах талаар санал өгсөн.

-Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2024 оны А/116 дугаар тушаалаар батлагдсан “Эрдэмт монгол” зорилтот арга хэмжээний хүрээнд 2025 онд элсэлтийн ерөнхий шалгалт өгөх сурагчдад зориулан монгол хэл, математик, англи хэл, нийгмийн ухааны хичээлийг цахим хэлбэрээр 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 30-ны өдрийн хооронд зохион байгуулахтай холбоотой

тасгийн хэмжээнд 11-12 дугаар ангийн 4 хүүхдийг хамруулах тухай саналаа 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр хүргүүлж бүрэн хамрагдсан.

ХОЁР: ХУУЛИЙН ЭТГЭЭД, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛ

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр:


2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн байдлаар эд хөрөнгийн нийт **4960** бүртгэлийн мэдүүлэг хүлээн авч, холбогдох бүртгэлийг Улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хөтлөн бүртгэж, цахимжуулан хадгалсан.

- **Анхны бүртгэл 457**
- **Өмчлөх эрх шилжих гэрээний бүртгэл 584**
- **Эд хөрөнгийн бүртгэлд өөрчлөлт оруулах бүртгэл 274**
- **Барьцааны гэрээ болон дуусгавар 3527**
- **Архивын лавлагаа, хуулбар, хувийн хэрэг хаах бүртгэл 112**
- **Түрээсийн гэрээ - 6**

2025 оны хагас жилийн байдлаар УАБ У.Золзаяа 173, улсын бүртгэгч Т.Алтаншагай 53, улсын бүртгэгч Д.Мягмар 104, улсын бүртгэгч А.Оюунсүвд 1768, улсын бүртгэгч Т.Мягмарсүрэн 1757, улсын бүртгэгч С.Баярмаа 900, улсын бүртгэгч Ц.Ганчөдөр 61, Ж.Оргилмаа 8, Б.Ууганбаяр 68, З.Ёндонжамц 23, Ц.Эрдэнэчимэг 45 бүртгэл тус тус хийсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн нийт үзүүлсэн үйлчилгээнээс улсын төсөвт үйлчилгээний хураамж **157 013 038** төгрөгийг, орон нутгийн төсөвт тэмдэгтийн хураамж **21 356 655** төгрөгийг, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны орлогын албан татвар **343 325 066** төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийг төрлөөр нь ангилан графикаар харьцуулан харуулбал:



Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлд зааснаар хуулийн байгууллагын албан бичиг 220, иргэн хуулийн этгээдийн өргөдөл хүсэлтэд 20 нийт 240 лавлагаа мэдээлэл олгосон байна. Тус өргөдөл гаргасан иргэнд Баянхонгор аймгийн сум дундын шүүхэд өмчлөгчөөр тогтоолгох тухай хүсэлт гаргах нь зүйтэй гэсэн хариу өгсөний дагуу иргэн шүүхээр өмчлөгчөөр тогтоолгосон байна.

Тайлант хугацаанд Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбогдуулан нийт **1315** гэрчилгээ бичиж олгосон байна.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивт 2024 оны 11 сарын 13 - аас 2024 оны 06 сарын 03-ны өдрийн байдлаар нийт 4960 бүртгэлийн нотлох баримтыг архивт шилжүүлэн өгсөн байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр

Тайлант хугацаанд буюу 2024 оны 11 сарын 26-ны өдрөөс 2025 оны 06 сарын 03-ны өдрийг хүртэлх хугацаанд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр үйлчилгээ авахаар ирсэн иргэн, аж ахуй нэгжид дараах бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлж ажилласан байна.

Тайлант хугацаанд хуулийн этгээдийн нийт 1104 бүртгэл бүртгэгдсэн байна. Үүнээс шинээр бүртгэгдсэн хуулийн этгээд 175, хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн бүртгэл 200, лавлагаа, тамга тэмдэг, гэх мэт бусад бүртгэл нийт 726, татан буугдсан бүртгэл 3 хөтөлсөн байна.

2024 оны 11 сарын 26-ны өдрөөс 2025 оны 06 сарын 03-ны өдрийн байдлаар бүртгэгдсэн хуулийн этгээдийн бүртгэлийн төрлийг дараах графикаар дэлгэрэнгүй харуулбал: Үүнд:



Хуулийн этгээдийн улсын бүртгэлтэй холбоотой хууль тогтоомж, журмыг судлах, түүнд нийцүүлэн үнэн зөв бүртгэл хөтлөх, хуулийн этгээдийн цахим мэдээллийн санд алдаагүй, зөв бүртгэх, эх нотлох баримтын цахимжуулалтыг тухай бүрт цахимжуулж цаасан нотлох баримтыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2019 оны А/1050 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн этгээдийн хувийн хэргийг архивт шилжүүлсэн дэвтэр”-р, мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн баримт бичгийг архивт шилжүүлэхдээ уг тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан “Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн баримт бичгийг архивт шилжүүлсэн жагсаалт”-р тус тус архивын цаасан суурьт эх нотлох баримт материалыг ажлын 5 хоногийн дотор архивчид хүлээлгэн өгч ажилласан.

Мөн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг цэгцлэх, тулгалт хийх ажлыг зохион байгуулан ажиллаж, цахим мэдээллийн санд зөрүүтэй хадгалагдсан, дугаарлалт алдаатай, дутуу цахимжуулсан гэх мэт зөрчлийг тасгийн дарга У.Золзаяа, хуулийн этгээдийн улсын бүртгэгч Д.Отгонсүрэн нар хамтран хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх эрх авсан сумын улсын бүртгэгч нарын 2024 оны 08 сараас 2025 оны 03 сар дуусталх нийт 193 бүртгэлийг шалган холбогдох улсын бүртгэгч нарт танилцуулан цахимжуулалт болон дугаарлалт алдаатай бүртгэлийг мэдээллийн санд залруулах ажил хийгдэж байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах тухай дараах саналыг хүргүүлсэн байна.

1.10.3.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 10.1.-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр, бусад баримт бичгийг тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ.

“Хүргүүлнэ” гэснийг “бүртгүүлнэ” гэж өөрчлөх мөн ажлын 15 өдөр гэснийг шийдвэр гарснаас 30 өдрийн (хоног) дотор улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ гэж өөрчлөх;

Тайлбар: Өнөөдрийн байдлаар 10.1.-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр, бусад баримт бичгийг тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад “хүргүүлсэн” тохиолдол байхгүй байна.

2.10.4-д Эрх бүхий төрийн байгууллагаас зөвшөөрөл авч бүртгүүлдэг өөрчлөлтийн хувьд тухайн байгууллагын зөвшөөрөл олгосон шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш энэ хуулийн 10.3-т заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ;

Тайлбар: Төрийн байгууллагуудын тухайд хуульд заасан ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад “хүргүүлэх” (бүртгүүлэх) тохиолдол цөөн дийлэнх нь хуульд заасан хугацаа хэтрүүлж мэдүүлэг гаргадаг. Засгийн газар, Яам, агентлагуудаас гарч буй шийдвэр нь удаж ирдэг, 10.4-д заасан хүлээн авсан өдрөө нотолж чадахгүй тохиолдол байна. Мөн хуульд заасан “хүлээн авсан өдөр”-г хэрхэн нотлох талаар журмаар тодорхой зохицуулах;

3.10.6-д Хуулийн этгээдийн мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд улсын бүртгэлийн байгууллага холбогдох татвар төлсөн талаарх татварын албаны тодорхойлолтыг үндэслэн өөрчлөлтийг бүртгэнэ;

4.20.1.8-д.....өөрчлөн байгуулагдах үеийн тайлан, тэнцэл “Татварын албаны тодорхойлолт, тайлан тэнцэл” гэснийг хасах;

Тайлбар: Татварын албаны тодорхойлолт болон өөрчлөн байгуулагдах үеийн тайлан тэнцэл ач холбогдолгүй байна. “Өртэй” бол бүртгэхгүй гэх үндэслэл байхгүй, мэдээллийн санд ач холбогдолгүй нотлох баримтыг оруулж байна гэж үзэж байна;

5.12.1.-д.....ажлын 2 өдрийн дотор шийдвэр гаргаж.....

Тайлбар: Хуулийн этгээдийн улсын бүртгэлийг хөтлөхөд олон салбар хуулиудыг уншиж судлах, харах шаардлагатай хугацаа их зарцуулдаг, эрх зүйн дүгнэлт өгч шийдвэр гаргахад хоног давчуу, улсын бүртгэлийг үнэн зөв, алдаагүй хөтлөхөд тухайн хугацаа богино байх тул хугацааг нэмэх саналтай байна;

6.22.1.1.-д Нэр өөрчлөх тохиолдолд шинээр олгосон нэрийн баталгаажуулалт, өдөр тутмын сонинд зарлуулсан зар...

Тайлбар: Өнөөдрийн цахимжсан нийгэмд өдөр тутмын сонинг унших хүн ховор, үүний оронд бүртгэлийн байгууллагын эсхүл төрийн байгууллагуудын нэгдсэн цахим зарын сайттай болж мэдээлэл солилцдог болох саналтай байна гэх саналыг;

Хуулийн этгээдийн нэр баталгаажуулах журамд өгсөн санал:

Хуулийн этгээдийн нэрэнд тавигдах шаардлага, хязгаарлалт дээр:

- Журмын 3.10.4-д Баталгаажуулах нэр нь бичвэр, хэлбэр, авианы дуудлагын хувьд хуулийн этгээдийн нэрийн санд бүртгэгдсэн нэрийн үгийн үндэс, үеэр төсөөтэй бол.....

Тайлбар: Амарбаясгалант гэх нэр баталгаажсан байхад Баясгалант-Амар гэх нэрийг баталгаажуулахгүй байх;

- 3.10.11.Хуулийн этгээдийн нэрэнд дараах үгийг хуулиар хориглосон эсхүл нийтийн ёс суртахууны хэм, хэмжээнд сөргөөр нөлөөлөх, эмх замбараагүй байдал үүсгэх, өдөөн турхирах байдлаар бичсэн бол..... Араатан хоршоо гэх;
- Хуулийн этгээдийн нэр Монгол хэлээр, крилл үсгээр илэрхийлэгдсэн байна, мөн тухайн үгийг монгол хэлэнд орчуулахад нэр, үгийн утга давхардахгүй байна гэж оруулах;

Тайлбар: Монголоор “Инээмсэглэл” нэртэй компани бүртгэгдсэн байвал англиар “Смайл” гэж нэрлэн бүртгүүлж болохгүй талаар оруулах /Англи болон төвд хэлээр сонгосон нэр нь давхардахгүй боловч монгол хэлэнд орчуулахад давхардаж байна. Монгол хэлээр тухайн нэрийг авч чадахгүй бол өөр хэлээр орчуулан авч байна гэх саналуудыг УБЕГ-т хүргүүлсэн байна.

Төрийн бус байгууллагын тайланг хуулийн хугацаанд буюу 2025 оны 02 сарын 15-ны өдрийн дотор 2 тайлан хүлээн авч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт мэдээлэл хүргүүлж ажилласан.

2025 оны хагас жилийн байдлаар мэдээллийн сангаас иргэн, хуулийн этгээдэд олгосон лавлагаа, хуулбар, төрийн бус байгууллагаас ирүүлсэн тайланг архивын нэгж болгон үдэж хүлээлгэн өгсөн.

2025 оны 06 сарын 03-ны байдлаар өөр аймаг, хотоос шилжин ирсэн “Хөтөл мөнх ундром” /3763145/ ХХК, “Эрхт хур” /3133958/ ХХК, “Креативтийн” /5619181/ ХХК, “ХОДУТЭ” /6472567/ ХХК, “Дэвжих гүн төмөр” /8338841/ ХХК, “Ачит сэргээгч” /7055945/ ХХК, дээрх 6 хуулийн этгээдийн хувийн хэргийг бичиг хэргийн ажилтнаас

хүлээн авч хуулийн этгээдийн хувийн хэргийн шилжилт хөдөлгөөний бүртгэлийн дэвтрийг хөтлөн хувийн хэргийг тухай бүр архивчид хүлээлгэн өгч ажиллаж байна.

Тайлант хугацаанд тус хэлтсээс өөр аймаг, хотруу шилжин явсан “Юмжир трэйд” /3134652/ ххк, дээрх 1 хуулийн этгээдийн цаасан суурьт хувийн хэргийг УБЕГ-ын Нэгдсэн архивын газарт тус хэлтсийн албан тоотоор хүргүүлэн ажилласан.

Тамга тэмдгийн хяналтын дугаарын бүртгэл нийт 270 олгож бүртгэсэн байна. Хуулийн этгээдийн элэгдэж хуучирсан, ашиглах боломжгүй тамга тэмдгийн хураан авах, хяналтын дугаар дахин олгох, хаяж үрэгдүүлсэн тамга тэмдэг, хяналтын дугаарыг дахин олгох, татан буугдсан, хэлбэр, нэр өөрчлөгдсөн хуулийн этгээдийн тамга, тэмдэг нийт 16 хураан авсан.

Тайлант хугацаанд шинээр үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн оноосон нэрийн баталгаажуулалт нийт 271 нэр олгосон байна. Үүнээс биечлэн ирсэн авсан 107, цахимаар 164 хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал e-business.mn хуулийн этгээдийн улсын бүртгэлийн хүсэлт цахимаар илгээсэн нийт 870 үүнээс зөвшөөрсөн 164 татгалзсан 501, баталсан 205 хүсэлтийг хүлээн авч тухай бүр цаг хугацаанд нь түргэн шуурхай шийдвэрлэж ажилласан.

Эхний хагас жилийн байдлаар хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээг гарган сар бүрийн 25-ны өдрөөр тасалбар болгон ХЭУБГ-т 5 удаа цахимаар илгээж ажиллалаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээний орлогын мэдээг 5 удаа ХЭУБГ-т, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн архивын мэдээг 5 удаа гаргаж УБЕГ-ын нэгдсэн архивын газарт хүргүүлсэн.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үнэт цаас ашигласны мэдээг 5 удаа гаргаж хэлтсийн нярав, нягтлан бодогч нарт хүлээлгэн өгсөн бол хагас жилийн байдлаар хүчингүй болгосон үнэт цаас байхгүй болно.

Хуулийн этгээдийн улсын бүртгэгчээс 2025 онд бүртгэл хөтлөгдсөн нийт 604 баримтыг архивт хүлээн авч хадгаламжийн нэгж үүсгэн, тавиурт байршуулан ажилласан байна.

Хуулийн этгээдийн архивын сейф, шүүгээний эмх цэгцгүй байдлыг нэг бүрчлэн сайжруулан, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн дэвтрийг он оноор нь төрөлжүүллээ.

Хуулийн этгээд, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн нь дараах хурлуудыг хийж зохион байгуулалтын арга хэмжээ ав ажилласан байна.

- 02 дугаар сарын 05-ны өдөр улсын бүртгэгч нарт цаг үеийн асуудалтай холбоотой мэдээлэл өгч мөн хариуцлагатай, харилцаа хандлага дээрээ анхаарах, ёс зүйтэй байх, түргэн шуурхай байх, хууль дүрэм, журмаа чанд мөрдөж ажиллах талаар заавар мэдээлэл өгсөн ба хэлтсийн бүртгэгч нар танхимаар сумдын бүртгэгч нар цахимаар хамрагдсан байна.

-04 дүгээр сарын 05-ны өдөр улсын бүртгэгч нарт УБЕГ-ын Удирдах ажилтны зөвлөгөөнд явсан талаар мөн бүртгэлийн багц хуульд өөрчлөлт оруулах, бүтцийн өөрчлөлт оруулах, 2024 онд хийж хэрэгжүүлсэн ажил болон 2025 онд хийж хэрэгжүүлэх ажил болон анхаарах асуудлын талаар мэдээлэл өгч хэлтсийн бүртгэгч нар танхимаар сумдын бүртгэгч нар цахимаар хамрагдсан.

-2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр улсын бүртгэгч нарт “Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухайн хууль”-д өөрчлөлт орж байгаатай холбогдуулан санал авах талаар мэдээлэл өгөхийг үүрэг болгох хуралд хэлтсийн төвийн бүртгэгч нар танхимаар, сумдын бүртгэгч нар цахимаар тус тус хамрагдсан.

ДӨРӨВ. БҮРТГЭЛИЙН ХЯНАЛТ;

4.1.Бүртгэлийн хяналт хийсэн талаар:

Нэг. 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар бүртгэлийн төрөл тус бүрд хяналт тавьсан байдал.

Иргэний бүртгэлийн чиглэлээр 434, Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр 1291, Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 157, Архивын чиглэлээр 277, нийт 2163 бүртгэлд хяналт тавин ажиллалаа. **Хяналтын явцад** Иргэний бүртгэлийн 10, Эд хөрөнгийн чиглэлээр 46, нийт 56 зөрчил илрүүлснийг тухай бүр залруулж ажиллав.

2025 оны эхний хагас жилд төлөвлөгөө бус шалгалт 2 хийгдэж 1450 бүртгэл хамрагдсан. Өргөдөл, санал, гомдлын мөрөөр хийсэн шалгалт-342 байна.

Хоёр. Зөрчлийн тухай хуулийн хэрэгжилт. Зөрчлийн тухай хуульд заасны дагуу нийт 246 иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэв. Үүнээс 245 иргэн, 1 хуулийн этгээдэд шийтгэл ногдуулж, улсын төсөвт 5400000 төгрөгийн орлого төвлөрүүллээ. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэхдээ иргэн, хуулийн этгээдийн эрх, эрх чөлөөг хүндэтгэж, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчихгүй байхад анхаарч ажиллаж байна. Мөн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа хуульд заасны дагуу Прокурорын байнгын хяналтан дор хугацаанд нь хянуулан хамтран ажиллаж байна.

Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2025 онд 16, 25, 45 насанд хүрч буй өөрийн харьяалах сумын иргэдэд Багийн засаг дарга, нийгмийн ажилтантай хамтран утсаар холбогдож хуулийн хугацаандаа бүртгэл хийлгэхийг зөвлөж, мэдээллэж ажиллахыг сумдын улсын бүртгэгчдэд байнга зөвлөж ажиллаж байна.

Хэлтсээс энэ талаар анхааруулга санамж постер бэлтгэж цахим хуудаст байршуулан сурталчилж байна.

Гурав. Хяналтын улсын байцаагчийн дүгнэлтийн талаар.

Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн хамт олон бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, алдаа зөрчил гаргахгүй, улсын бүртгэлийг хууль зүйн дагуу үнэн зөв бүртгэл хөтлөх зорилтыг тавин ажиллаж байна.

2025 оны 05 сарын 25-ны өдрийн байдлаар Хяналтын улсын байцаагчийн нийт 44 дүгнэлт гаргаснаас бүртгэлийн төрөл тус бүрээр төрлөөр харуулбал: Үүнд:

№	Иргэний бүртгэлийн дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тоо
1	Бүртгэлд засвар, өөрчлөлт оруулах тухай	12
2	Бүртгэлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	5
2	Бүртгэл хүчингүй болгох тухай	6
3	Регистрийн дугаар өөрчилж, дахин олгох тухай	4
	Нийт	27ш

№	Эд хөрөнгийн бүртгэлийн дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тоо
1	Эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг хүчингүй тооцсон тухай	11
2	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай	2
	Нийт	13ш

№	Хуулийн этгээдийн бүртгэлийн дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тоо
1	Тамга тэмдэг хяналтын дугаарыг хүчингүйд тооцсон тухай	3
2	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай	1
	Нийт	4ш

Бүртгэлийн төрлөөр ангилвал.

№	Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тоо
---	------------------	----------------

1	Иргэний бүртгэл	27
2	Хуулийн этгээдийн бүртгэлийн талаар	4
3	Эд хөрөнгө	13
	Нийт	44ш

Хяналтын улсын байцаагчаас гарсан шийдвэрийг харуулбал:

№	Хяналтын улсын байцаагчийн	тоо
1	Хяналтын улсын байцаагчийн дүгнэлт	44
2	Хяналтын улсын байцаагчийн шийтгэлийн хуудас	246
3	Хяналтын улсын байцаагийн мэдэгдэл	0
4	Хяналтын улсын байцаагчийн акт	0
5	Хяналтын улсын байцаагчийн албан шаардлага	0
	Нийт	290ш

Дөрөв. Бусад ажлын талаар

2025 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар иргэн хуулийн этгээдээс ирүүлсэн нийт 25 өргөдөл, гомдол хүлээн авснаас 1 өргөдлийг иргэний өөрийн хүсэлтийн дагуу буцаасан, 24 өргөдлийг хяналтын улсын байцаагчийн дүгнэлтээр бүрэн судлан шийдвэрлэсэн байна.

Мөн хэлтсийн эрх бүхийн албан тушаалтны нийт 20 хүсэлтийг хүлээн авсан байна. Үүнээс эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой 12 хүсэлт, Иргэний бүртгэлтэй холбоотой 4 хүсэлт, хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой 4 хүсэлтийг тус тус хүлээн авснаас иргэний 1 хүсэлтийг буцаасан, бусад хүсэлтийг бүрэн судлан шийдвэрлэлээ.

Хяналтын шалгалтын төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 8 арга хэмжээг төлөвлөн батлан хэрэгжүүлж байгаагаас хэрэгжилт 50 хувьтай байна.

**ТАВ. САНХҮҮ, ТӨСВИЙН УДИРДЛАГА, ТӨЛӨВЛӨЛТ БОЛОН
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

Улсын бүртгэлийн хэлтэс нь 2025 оны 05 сарын 30-ны өдрийн байдлаар улсын төсвөөс 676.505.3 мянган төгрөгийн урсгал санхүүжилт авч цалин хөлсний зардалд 544.046.4, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 68.792.5, гэрэл цахилгааны зардалд 2.400.0, түлш халаалтын 37.000.0, цэвэр бохир усны зардалд 718.3, бичиг хэргийн зардалд 4.971.2, шуудан холбооны зардалд 1.097.3, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардалд 540.0, урсгал засварын зардалд 200.0, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 22.0, мэдээллийн технологийн зардалд 900.0 мянган төгрөг зарцуулж улсын төсвийн орлогын дансанд үндсэн үйл ажиллагааны орлого 174.507.5 мянган төгрөгийг улсын төсвийн дансанд төвлөрүүлэн ажиллаж байна.

УБЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтсээс 803.0 мянган төгрөгийн үнэт цаас, хангамжийн материал, төсвийн хөрөнгөөр 6.711.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан байна. Бараа материалын данснаас 3.862.5 мянган төгрөгийн үнэт цаас, хангамж, бусад бараа материалд хөдлөл өөрчлөлтөөр бүртгэн сар бүр үнэт цаасны тайлан няравын тайланг гаргуулан авч Санхүү, аж ахуйн хэлтэст хүргүүлж хэвшсэн.

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж сар, улирал, хагас жилийн тайланг УБЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтэст 5 удаа, Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Нийгмийн даатгалын газарт сар бүр ,Татварын газарт улирал бүр тайлан мэдээг хуулийн хугацаанд баталгаажуулан харилцагч байгууллагуутдай тооцоо нийлж өглөг, авлага үүсгэхүй байх тал дээр анхааран ажиллаж байна.

Байгууллагын 2026 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөллийг хуулийн хугацаанд гарган УБЕГ-т хүргүүлэхээр бэлтгэгдэж байна.

Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын тогтоолын дагуу байгууллагын санхүүгийн мэдээллийг www.shilendans.gov.mn, сайтад сар бүр тогтмол байршуулан 68 удаагийн мэдээлэл шинэчилж, www.bayankhongorburtgel.com сайтад тогтмол байршуулан 5 удаагийн мэдээлэл шинэчилж ажилласан.

2024 оны Санхүүгийн тайлан, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Төрийн Аудитын байгууллагаар шалгагдаж “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан боловч 2 албан шаардлага авч, хэрэгжилтийг ханган ажиллаж биелэлтийг хугацаанд нь гарган хүргүүлсэн.

202 оны 5 дугаар сарын 30-ны байдлаар батлагдсан төсөв хүрэхгүйгээс шалтгаалан түлш халаалтын зардалд 6.989.4, гэрэл цахилгааны зардалд 271.3, хог хаягдлын зардалд 500,0, мэдээллийн технологийн зардалд 750.0 нийт 8.510.7 мянган төгрөгийн тус тус өглөгтэй байна.

ЗУРГАА.БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АЖИЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААГ СУРТАЛЧЛАХ АЖИЛЛАГАА

6.1.Байгууллагын архив, бичиг хэргийн эргэлтийн бүртгэл, тайлан

Хэлтсийн хэмжээнд 2025 оны 06 дугаар сарын 10-ны байдлаар ирсэн албан бичиг 458, Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын даргын тушаал, чиглэл, албан даалгавар 17, дотоод албан бичиг 4 тус тус бүртгэгдсэн байх ба хэлтсээс 523 албан бичиг явуулсан байна.

Ирсэн, явсан албан бичиг болон өргөдөл, гомдлыг ер системд бүртгэн хяналт тавин ажиллаж байна.

Хэлтэст нийт 384 **хариутай албан бичиг ирүүлсэн ба** хуулийн хугацаа хэтрүүлэн хариу илгээсэн албан бичиг 20 байна. Энэ нь албан бичгийг шийдвэрлэж хариу өгсөн атлаа системд хоцорч хаасан тохиолдлууд байна.

Удирдлагаас гарах шийдвэрийн болоод зохион байгуулалтын баримт бичиг буюу Хэлтсийн даргын тушаал 9, хамт олны хурлын тэмдэглэл 5 гарсан байна.

6.2 Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлт

Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу байгууллагад ирсэн өргөдлийг бүртгэлжүүлэн хариуг хуулийн хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна. 2025 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийт 24 өргөдөл ирсэн. Үүнээс бүрэн шийдвэрлэсэн 22 буюу 91,6 хувьтай байна. Харин 1 өргөдлийг эзэн нь өөрийн биеэр гаргаагүй байсан тул буцааж, судлагдаж буй 1 өргөдөл байна. Өргөдөл гомдлын мэдээг тогтоосон цаг хугацаанд Улсын бүртгэлийн Ерөнхий газар болон аймгийн Төрийн захиргааны удирдлагын хэлтэст тус тус хүргүүлэн ажиллаж байна.

6.3 Үйл ажиллагааг сурталчилсан байдал

УБЕГ-аас нэгдсэн байдлаар үүсгэн хөтлөж буй хэлтсийн вэйб хуудсанд хэлтсээс хийж хэрэгжүүлж буй ажил үйлчилгээ, зохион байгуулсан сургалт, цаашид хийж хэрэгжүүлэх ажлууд, бүртгэлийн тоон мэдээ, нээлттэй ажлын байрны зар болон цаг үеийн мэдээ мэдээллийг тухай бүр нь байршуулж иргэд олон нийтэд түгээн дэлгэрүүлж ажиллаж байна. /Bayankhongor.burtgel.gov.mn/ Тус хаягт эхний хагас жилийн байдлаар 45 мэдээ мэдээлэл, үйл ажиллагааг сурталчлан байршуулсан байна. Баянхонгор аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтэс гэсэн фэйсбүүк пэйж хуудсанд 274 удаагийн мэдээ мэдээллийг тавьж байршуулан иргэд олон нийтэд сурталчилж хамгийн олон хандалт авсан мэдээ мэдээлэл нь хэлтсийн Эцэг эхийн зөвлөлөөс 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Улсын бүртгэлийн байгууллага үүсч хөгжсөний 85 жилийн ой, Олон улсын гэр бүлийн өдрийг угтан гэр бүлийн үнэ цэнэ, хайр хүндлэл, эерэг харилцааг дэмжих, халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлэх, хайртай гэр бүлтэйгээ нэг өдрийг дурсамж бүтээн өнгөрүүлэх зорилгоор хэлтсийн алба хаагчдын гэр бүлүүдийн дунд "ХАЙР ТҮГЭЭЭ" арга хэмжээг зохион байгуулсан тухай мэдээ мэдээлэл, АВЛИГЫН ЭСРЭГ НЭГДЬЕ.@Үгүй_гэж_хэлээд_өөрчлөө. @авлигыг_мэдээлэх_утас_110 гэсэн контент, Улсын бүртгэлийн байгууллагын 85 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөний дагуу 2025 оны 5 дугаар сарын 8-9-ний өдрүүдэд албан

хаагчдын нэгдсэн сургалтын хүрээнд “Ахмадаа сонсьё” дурсамж уулзалтыг зохион байгуулж, байгууллагад олон жил ажилласан ахмадуудаа урьж, тэдний үнэтэй туршлага, дурсамжийг хуваалцан, хүндэтгэл үзүүлсэн, үе үеийн албан хаагчдын сургалт, зөвлөгөөн болон ажил, амралтын үеийн дурсамжуудаас бүрдсэн гэрэл зургийн цомгийн үзэсгэлэн гаргасан тухай мэдээллүүд тус тус байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн чиглэлийн дагуу 2025 оны .. хэлтсээс хийж хэрэгжүүлсэн ажлын талаарх 6 мэдээллийг n.sumyasuren@burtgel.gov.mn хаягаар хүргүүлэн хянуулж тус тус байршуулан ажиллаж байна.

Хэлтсийн албан хаагчдад УБЕГ болон хэлтсээс зохион байгуулсан ажил үйлчилгээ, орон нутгийн төр захиргааны байгууллагын бодлого шийдвэрийг сурталчлахад идэвхтэй оролцон холбогдох цахим хаягуудад хандалт хийж уншиж танилцаж, шэйр хийн хууль тогтоомжийг сурталчлан таниулах үүргээ гүйцэтгэж идэвхтэй ажиллах үүргийг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд арга хэмжээ болгон тусган хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж хэвшсэн.

6.4 Гадагш чиглэсэн сургалт, үйл ажиллагаа

"Цахим элч" сургагч багш нарын чадавхжуулах сургалт зохион байгуулагдлаа.

Төрийн цахим үйлчилгээг сурталчлах, иргэдийн төрийн цахим үйлчилгээ авах ур чадварыг эзэмшүүлэх, ур чадварыг нэмэгдүүлэхэд чиглэсэн нөлөөллийн ажлуудын хүрээнд бэлтгэгдэж байгаа "Цахим ур чадварын сургагч багш" буюу "Цахим элч" сурагч багшийг чадавхжуулах сургалтыг 2025 оны 04 дүгээр сарын 3-ны өдөр амжилттай зохион байгууллаа.

Тус сургалтад эхний ээлжийн 15 хүүхэд хамрагдаж, "E-Mongolia нэвтрэх, үйлчилгээ авах", "Canva программ дээр постер бэлтгэх аргачлал", "Зангиа академид бүртгүүлэх" сэдвийн хүрээнд практик сургалтыг хийж, бүрэн чадавхажлаа.



Баянхонгор аймгийн улсын бүртгэлийн хэлтэс нь 2024 оноос эхлэн аймгийн Төрийн цахим үйлчилгээний хэлтэс, Насан туршийн суралцахуйн төвтэй хамтран иргэдийн цахим үйлчилгээ авах ур чадварыг дээшлүүлэх нөлөөллийн ажлыг амжилттай зохион байгуулжээ. Тодруулбал, "Тоон гарын үсгийн хэрэглээ, тоон гарын үсгийн түлхүүр, түүний хадгалалт, хамгаалалт", Төрийн цахим үйлчилгээний хэлтсээс "Цахим орчинд хувийн мэдээллээ хамгаалах, кибер аюулгүй байдлаас урьдчилан сэргийлэх" талаар мэдээллийг хүргэсэн байна.

- Ахлах ангийн 150 орчим сурагчийг “Цахим ур чадварын сургагч багш”-аар бэлтгэж, тэдгээр сурагчид ахмадуудыг сургах эхний ээлжийн баг болгон ажиллаж байна.



- 2025 оны 5 дугаар сарын 15-ны өдөр Баянхонгор суманд аймгийн Ахмадын холбоо, орон нутгийн ахмадын хороотой хамтарч 30 гаруй ахмад насыг хамруулсан сургалт амжилттай явагдлаа.

Сургалтын үеэр дараах үйл ажиллагаанууд зохион байгуулагдав:

- Улсын бүртгэлийн байгууллагаас тоон гарын үсэг (G-sign) олголтын үйлчилгээ үзүүлэх, хэрэглээ, түлхүүрийн хадгалалт, хамгаалалтын талаар мэдээлэл хүргэлээ.
- Төрийн цахим үйлчилгээний хэлтсээс цахим орчинд хувийн мэдээллээ хамгаалах, кибер аюулаас урьдчилан сэргийлэх зөвлөмж, практик дасгалуудыг зааж сургажээ.
- Насан туршийн суралцахуйн төвийн н.Нансал багш “Цахим элч сургагч багш” хүүхдүүдтэйгээ хамтран ахмадуудын гар утсан дээр G-sign болон e-Mongolia аппликейшнуудыг суулгах, цахим үйлчилгээг хэрхэн авах аргачлалыг зааж, анхан шатны мэдлэг, чадварыг эзэмшүүлсэн үр дүнтэй сургалт боллоо.


ДОЛОО. БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТ, ХӨГЖИЛ, ЁС ЗҮЙ

7.1. Албан хаагчдын сургалт, хөгжил

Байгууллагын нийт албан хаагчдыг чадавхжуулах, мэдлэг чадварыг дээшлүүлэх, төрийн албан хаагчийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор хэлтэс нь сургалт, сурталчилгааны ажлын төлөвлөгөөг хагас бүтэн жилээр батлан хэрэгжүүлж хэвшсэн бөгөөд эхний хагас жилийн төлөвлөгөөний дагуу хэлтсийн дотоод сургалт нийт 11 удаа амжилттай зохион байгуулагдаж ирцийн хуудсаар идэвхи оролцоо бүртгэгдсэн байна. Дээрх төлөвлөгөөт сургалтаас гадна жил бүр хийж хэвшсэн хэлтсийн албан хаагчдын Нэгдсэн сургалтыг мөн тусгай хөтөлбөр гарган хэрэгжүүлж 5 дугаар сарын 8-9-ний өдөр зохион байгуулж ирц 100 хувьтай оролцлоо. Сургалтуудаас дурьдвал:

-Хэлтсийн 2025 оны эхний сургалтыг ЭБАТ хэлтсийн даргаас 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 08.00 цагт “2024 оны хөрөнгө орлогын мэдүүлэг, түүнийг мэдүүлэхэд анхаарах асуудал” сэдвээр зохион байгуулав. Сургалтад хэлтсийн төвийн албан хаагчид танхимаар, сумдын албан хаагчид цахимаар бүрэн хамрагдав.

- 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга П.Бүжинлхам "Авлига,ашиг сонирхлын зөрчил, бүртгэлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь", "Иргэний улсын бүртгэл хөтлөхөд гарч буй зөрчил, цаашид анхаарах асуудал" сэдвээр тус тус сургалт мэдээлэл хийлээ.




- 2025.03.12-ны Лхагва гарагийн сургалт мэдээллийн цагаар "Зөөлөн ур чадвар" сэдвээр Насан туршийн суралцахуйн төвийн багш П.Даарийсүрэн сургалт хийлээ.

-Хэлтэс нь Жендэрийн Үндэсний хорооноос жил бүр зохион байгуулдаг "Харилцан хүндэтгэе" аянд нэгдэн, Жендэрийн хөгжил хандлага, жендэрийн тэгж бус байдлыг бууруулах агуулгын хүрээнд албан хаагчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн "Жендэр ба хөгжил хандлага" сэдэвт сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн буюу Лхагва гарагийн сургалт мэдээллийн цагаар зохион байгуулж, хэлтсийн албан хаагчдын дунд сэтгэл хүндэтгэлийн "Халуун сандал" ярилцлагыг өрнүүлсэн нь энэ удаагийн сургалтын онцлог байлаа.

өдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн сарын аяны хүрээнд аймгийн Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газрын мэргэжилтнийг урьж Хөдөлмөрийн аюулгүй байдлын асуудлаар байгууллага хүлээх үүрэг чиглүүлэх сургалтыг нийт албан хаагчдад 2025 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулж зөвлөгөө мэдээлэл авлаа.

-Ээлжит сургалтыг "Nudge" сэдвээр 2025 оны 04 дүгээр сарын 09-ний 08.00 цагт Насан туршийн суралцахуйн төвийн иргэний боловсролын багш Б.Мөнхнасан хийлээ.



-4 дүгээр сарын 15-ны Лхагва гарагт 08.00 цагт Англи хэлний Стандарт сургалтын төвийн багшаар албан хаагчдад "Англи хэлийг амжилттай сурах нь" сэдвээр мэдээлэл хийлгэв.



-4 дүгээр сарын 22 Лхагва гарагт Иргэний улсын бүртгэлийн тасгийн дарга бөгөөд ахлах бүртгэгч П.Бүжинлхам “Гэр бүлийн байдлын бүртгэл, түүний эрх зүйн зохицуулалт” сэдвээр сургалт хийж, хэлтсийн төвийн албан хаагчид танхимаар сумдын албан хаагчид онлайнаар хамрагдав.



Тус хэлтсээс аймгийн Насан туршийн суралцахуйн төвтэй 4 дэх жилдээ хамтран ажиллаж байна. Насан туршийн суралцахуйн төвд санал хүргүүлснээр тус байгууллагатай зөвшилцөн Байгууллагын 2025 оны сургалтын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлснээр уг байгууллагын сургагч багш нарын сургалт мэдээлэл, мэдлэгийг албан хаагчдадаа хүргэн ажиллаж байна.

Нийт албан хаагчдын идэвх оролцоог сургалт бүрийн ирцийн хуудсаар өөрсдийн гарын үсгээр баталгаажуулан бүртгэж ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд мэдлэг чадвар хэсэгт харгалзан үздэг болно.

УБЕГ болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалт, зөвлөгөөнд оролцсон талаар

Хэлтсээс дараах байдлаар идэвхтэй оролцож ажиллалаа.


Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 414 дугаарт албан бичгээр ирүүлсэн Баянхонгор аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс, Баянхонгор аймгийн Цагдаагийн газар, Баянхонгор аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газраас аяны хүрээнд 2024 оны 12 дугаар сарын 04-ны өдөр хамтран зохион байгуулсан “Хүүхдийн хүмүүжилд эцэг, эхийн оролцоо”, “Гэр бүл гэрлэлт”

сэдвүүдээр сургалт зохион байгуулсанд хэлтсийн харуул ажилтай Д.Даваадорж, улсын бүртгэгч А.Оюунсүвд нар хамрагдсан.

Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан ЭБАТ-уудад зориулсан онлайн сургалтад хэлтсийн дарга 1 сарын 03-ны өдөр хамрагдав.

-Байгууллагын жолооч, дарга нарт зориулсан сургалтыг Аймгийн Засаг даргын Тамгын газраас 2 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулсан бөгөөд хэлтсийн дарга, гэрээт харуул –жолоочийн хамтаар сургалтад хамрагдав.

- 2025 оны 03 сарын 10-ны өдөр Аймгийн удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөнд оролцож 2024 оны ажлаа дүгнүүлж Аймгийн засаг даргын эрхлэх асуудлын хүрээний Агентлагуудаас 5 дугаар байрт шалгаран “Өргөмжлөл” 1 сая төгрөг, Хууль эрх зүйн хэлтсээс зохион байгуулсан “Хууль дээдлэгч байгууллага” аянд 3 дугаар байр эзлэн 3 үйлдэлт принтер, Жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид ажиллах орчныг бүрдүүлэх, жендэрийн мэдрэмжтэй удирдлагыг бий болгох, жендэрийн мэдрэмжтэй ажлын байрыг шалгаруулах, алдаршуулах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор зохион байгуулсан "Жендэрийн мэдрэмжтэй төрийн байгууллага" шалгаруулах уралдаанд амжилттай оролцож "ТЭРГҮҮН БАЙР" эзэлж Өргөмжлөл 1 сая төгрөгөөр тус тус шагнагдлаа. Эдгээр шагналын мөнгөөрөө хэлтсийн хүүхдийн өрөөний тохижилт, хамт олны Гэр бүлүүддээ хүндэтгэл үзүүлэх зэрэг ажлуудад зарцууллаа.



Иргэний улсын бүртгэлийн газраас Хэлтсийн дарга нарт эрх нээх онлайн сургалтыг 4 дүгээр сард 15-нд зохион байгуулж хэлтсийн дарга хамрагдав.

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, чиглэлийг хэрэгжүүлэх, өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудлуудын талаар хүүхэд, гэр бүлийн өмнө үүрэг хүлээгчдийг мэдээллээр хангах, салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор “Хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн 6 дугаар зөвлөгөөн” 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулагдаж хэлтсээс дарга, хэлтсийн Эцэг эхийн зөвлөлийн гишүүдийн хамтаар нийт 5 хүн оролцов.



Өвөрхангай аймагт зохион байгуулагдсан "Бүсчилсэн хөгжил-төрийн албаны манлайлал" хангайн бүсийн зөвлөгөөнд хэлтсийн дарга оролцов. Энэхүү зөвлөгөөнийг Төрийн албаны зөвлөлөөс санаачлан зохион байгуулж Архангай, Өвөрхангай, Баянхонгор аймгийн 520 албан хаагч оролцож, эхний өдөр салбар хуралдаануудаар илтгэл мэдээлэл хэлэлцсэн бол 2 дахь өдөр "АйТи инсайт" ХХК-ийн гүйцэтгэх захирал Ч.Агиймаа "Дижитал төр-АИ бүтээмж ба технологийн шийдэл", Афа академийн багш Ш.Амартүвшин "Үнэт зүйл ба төлөвшил", Сэтгэл зүйч Г.Наранбаатар "Ажил амьдралын тэнцвэр" сэдвээр лекц уншиж, зөвлөгөө өгсөн нь



төрийн жинхэнэ албан хаагчдад шинэ санаа- сэдэл, шинэ зорилго зорилт, урам зориг өгсөн цаг үеийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үр дүнтэй зөвлөгөөн боллоо.

Цахим залилангаас урьдчилан сэргийлэх, мөнгөн тэмдэгтийн 100 жилийн ойд зориулсан санхүүгийн боловсрол олгох арга хэмжээ нь орон нутгийн төрийн албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх, мөнгөн тэмдэгтийн түүх, хэрэглээний соёлыг түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн чухал үйл ажиллагаа болсон бөгөөд тус арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан сургалтад хэлстийн хамт олон хамрагдлаа. Сургалтад ☒ Монголбанкны Баянхонгор аймаг дахь салбарын захирал Г.Олонбаяр "Мөнгөн тэмдэгтийн үүсэл хөгжил", "Мөнгөн тэмдэгтийн соёлтой хэрэглээ", "Хуримтлал" зэрэг сэдвээр мэдээлэл өгсөн.

☒ Цагдаагийн газрын ахлах дэслэгч Б.Ганбаяр "Цахим залилангийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь" сэдвээр мэдээлэл хийсэн.

☒ АЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн мэргэжилтэн Ж.Лхамдулам "Нийтийн албан тушаалтанд тавих хориглолт, хязгаарлалт" сэдвээр мэдээлэл өгсөн.



Улсын бүртгэлийн байгууллагын түүхт 85 жилийн ойн хүрээнд ажилтан, албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх "Спорт-2025" нэгдсэн сургалт зохион байгуулах тушаал, удирдамжийг ирүүлсэн дагуу хэлтсийн албан хаагчдаас төлөөллийг томилсноор хяналтын улсын байцаагч Л.Мэндбаяр, улсын бүртгэгч Г.Бадамханд, Ж.Оргилмаа, З.Ёндонжамц, Т.Алтаншагай нар оролцож, эрэгтэй сагсан бөмбөгийн төрөлд Хангайн бүсийн баг тамирчид хүрэл медаль хүртлээ.



Улсын бүртгэлийн байгууллагад хэрэгжижи буй “Монгол улсын Үндэсний бүртгэлийн системийн Дижитал чадамжийг бэхжүүлэх хөтөлбөр”-ийн 3 дахь удаагийн сургалтад БНСУ-д 2025 оны 06 дугаар сарын 1-15-ны өдрүүдэд хэлтсийн Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн дарга У.Золзаяа томилогдон оролцож байна.



Аймгийн Эрүүл мэндийн газраас зохион байгуулсан Хүний папиллома вирусын халдварын эсрэг вакцины ач холбогдлын талаар мэдээлэл өгөх сургалтад хэлтсийн төлөөлөл албан хаагчийг оролцуулснаар албан хаагчдад мэдээллийг түгээн ажиллав.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 715 дугаар тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу Төрийн өмчийг эзэмшүүлэх 2024 оны гэрээний биелэлтийг дүгнэх ажлын хэсэг 2025 оны 06 дугаар сарын 06, 07-ны өдрүүдэд тус аймагт ажиллалаа. Ажлын хэсэг нь хуулийн этгээдийн дарга, нягтлан бодогч, өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичиг нарыг оролцуулан сургалт зохион байгуулссан бөгөөд 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 09:00 цагт хэлтсийн холбогдох ажилтнууд хамрагдав.



9.2. Албан хаагчийн ёс зүйн асуудал

Улсын бүртгэлийн байгууллага нь төрийн үйлчилгээний 70 гаруй хувийг үзүүлдэг, мөн өдөр тутамдаа байнгын ачаалалтай ажилдаг зэрэг ажлын онцлогоос шалтгаалан харилцааны ур чадварыг цаг ямагт шаардаж байдаг тул алба хаагчдад хамгийн гол нь харилцаа хандлага л чухал түүнд анхаарч түүнийг эрхэмлэн ажиллахыг удирдлага болгон хянал тавин ажиллаж байна.

Иргэдийн сэтгэл ханамжийн байдлыг тандах, албан хаагчдын харилцаа хандлагыг сайжруулах, байгууллагын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, үйлчилгээний стандартыг мөрдүүлэх зорилгоор өргөдөл гомдол хүлээн авах 70440517 дугаарын утсыг тогтмол ажиллуулж байна. Өнөөдрийн байдлаар тус утсанд болон бигээр албан хаагчдын харилцаа хандлага, ёс зүйн асуудлаар ямар нэгэн гомдол мэдээлэл ирээгүй байна.

НАЙМ. ОРОН НУТАГ ДАХЬ ХАМТЫН АЖИЛЛАГАА

Аливаа байгууллага орон нутгийн удирдах байгууллага, түүний хамт олонтой нягт хамтран ажиллах нь төрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, байгууллага чиг үүргээ амжилттай хэрэгжүүлэх бас нэгэн тулгуур билээ. 2025 он гарсаар хэлтсээс орон нутагтай дараах байдлаар хамтарч ажиллалаа.

Баянхонгор сумын Засаг даргын захирамжийн дагуу сар бүрийн 12-ны өдөр хуваарьт газартаа бүх нийтийн цэвэрлэгээ хийхээр тогтоосон дагуу хэлтсийн албан хаагчид аймгаас баруун тийш зорчих хот хоорондын замын хоёр талаарх хог хаягдлыг 5 удаа цэвэрлэж дахивар хог хаягдлыг тушаах цэгт нь хүргэж өгч ажиллан энэ талаарх тайлан мэдээллийг байгууллагын цахим хаягт байршуулахын зэрэгцээ Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газарт хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.



- 1 дүгээр сарын 20-ны өдөр Төрийн Аудитын газраас зохион байгуулсан санхүүгийн тайлангийн аудитын нээлтэнд хэлтсийн дарга, нягтлан бодогчийн хамт оролцов.

- Аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан Малчид төлчдийн зөвлөгөөнд оролцох 2 чиглэлд 2 ажилтанг томилон ажиллуулж Бүртгэлийн байгууллагын үйл ажиллагаа бусад /Хуулийн этгээдийн чиглэлээр/ зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав.

-Аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан удирдамжийн дагуу 02 дугаар сарын 05-ны өдөр “Хэлтсийн 2024 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлын хэсэг” ажиллаж, тэдгээрт байгууллагын 2024 оны үйл ажиллагааны танилцуулга мэдээллийг хийж, ажлаа шалгуулав.

-Терроризмтэй тэмцэх салбар зөвлөлийн хуралдаанд гишүүний хуваарь 3 сарын 24-ны өдөр оролцож харилцан мэдээлэл солилцож, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

-Аймгийн ГХУСА33-ийн батласан удирдамжийн дагуу “Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт арга хэмжээнд Эрдэнэцогт суманд улсын бүртгэгч Э.Адъяабаярыг томилон ажиллуулж “Тоон гарын үсэг түүний хэрэглээ, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь сэдэвт сургалтыг хийлгэв.

Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 104 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх хүрээнд цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх, байгууллага бүр өөрийн үйл ажиллагааг таниулах, иргэд олон нийтэд хууль тогтоомжийг сурталчлах, өргөдөл гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэхэд чиглэгдсэн “Нээлттэй хаалганы өдөрлөг” арга хэмжээнд 2025 оны 03 дугаар сарын 16-ны "Ням гараг" өдөр Улсын бүртгэлийн хэлтэс амжилттай хамтран оролцлоо. Уг арга хэмжээн дээр улсын бүртгэлийн явуулын 4G төхөөрөмжийг ашиглан улсын бүртгэлийн үйлчилгээ (иргэний, хуулийн этгээдийн болон эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн)-г үзүүлж, улсын бүртгэлийн цахим шилжилт, улсын бүртгэлийн цахим үйлчилгээг хэрхэн авах талаарх сурталчилгаа танилцуулгыг хийв.



УИХ, ЗГ-ын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл Баянхонгор аймагт 4 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд ажилласан бөгөөд аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан болон хуулийн салбарын удирдлагуудтай уулзан санал хүсэлтийг сонсож, зарим асуудлыг шийдвэрлэв. Яамны харъяа байгууллагуудын үйл ажиллагааны танилцуулгад хэлтсийн холбогдох мэдээллийг бэлтгэн хүргүүлж, нэгтгэн танилцуулсан. Үүнд тус хэлтсийн хуулийн этгээд, эд хөрөнгийн бүртгэлийн архивын болон байгууллагын архивт нягтруулсан шүүгээ шаардлагатай байгаа талаар болон хэлтсийн автомашиныг шинэчлэх саналыг тус тус танилцуулж ажиллав.



Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэстэй хамтран 4 дүгээр сарын 28-аас 5 дугаар сарын 2-ны өдрийг хүртэл Бөмбөгөр, Бууцагаан, Баянбулаг, Хүрээмарал сумдад ажиллах баг бүрэлдэхүүнд тус сумдын улсын бүртгэгчид оролцож мэдээллийг хийж хамтран ажиллав.



- Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, ой, усны нөөцийг хамгаалж, нэмэгдүүлэх, экологийн тэнцвэрт байдлыг хангах зорилгоор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг санаачлан өрнүүлсэнд жил бүр нэгдэж ажилладаг бөгөөд энэ тайлант хугацаанд манай хэлтэс Бүх нийтээр мод тарих өдрийг тохиолдуулан 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр аймгийн төвийн хойд талаар хуваарилсан газарт 100 ширхэг модны ургалтын хувийг тодорхойлж шалгаж ажилласнаар цаашид амьдрах ургах чадваргүй болсон 25 модыг илрүүлсэн. Мөн талбайд нэмж 25 нүхийг ухаж шинээр 25 ширхэг улиас, нөхөн 25 улиас модыг тус тус тарьж суулган цэнэг усалгааг хийлээ.



- Аймгийн Төрийн албаны салбар зөвлөлөөс 3, 5 дугаар саруудад зохион байгуулсан төрийн албан хаагчийн шалгалтын комисст ажиллан, шалгалтанд оролцогчдын мэдээллийг хурууны хээгээр шалган оруулж хамтран ажиллалаа.

- Аймгийн Засаг даргаас 2025 оны Эрүүл мэндийг дэмжих жил болгон зарласан бөгөөд энэ хүрээнд зохион байгуулагдаж буй арга хэмжээнүүдэд хэлтсээрээ идэвхтэй оролцож байна. Өдөр бүр ажлын байрны дасгал хөдөлгөөн хийх, 4 сарын 18, 5 сарын 2,16-ны өдрүүдэд 07.00-



08.30 хооронд хамт олноороо бүжгийн сургалтад хамрагдлаа.

-“МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР”, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 104 ЖИЛИЙН ОЙН ТЭМЦЭЭН, УРАЛДААНД АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО.

Хэлтсээс ширээний теннисний эмэгтэй төрөлд тамирчин улсын бүртгэгч Т.Алтаншагай өрсөлдөж Мөнгөн медалийн эзэн болсон бол хэлтсийн эмэгтэй баг тамирчид гар бөмбөгийн төрөлд Мөнгөн медалийн эзэд боллоо.



Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, “Нүүлгэн шилжүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангуулах зорилтод арга хэмжээний хүрээнд орон даяар зарлагдан зохион байгуулагдаж байгаа зарлан мэдээллийн дохиогоор нүүн шилжих дадлага сургууль 03 дугаар сарын 27-ны өдрийн 16:00 цагт Баянхонгор аймагт зохион байгуулагдлаа.

Тус арга хэмжээнд хэлтсийн нийт албан хаагчид идэвхитэй хамрагдаж, гамшгийн үед эрсдлээс өөрийгөө болон өөрийн эргэн тойронд хамт байгаа гэр бүл, ахан дүүс, хамт олноо хэрхэн хамгаалах, гамшгийн үед мөрдөх заавчирлагаа, дүрмийг хэрхэн сахин мөрдөх, зарлан мэдээллэх дохио дуугарсаны дараа аюулгүй талбайд хэрхэн цугларах талаарх дадлага сургуулилтыг хийлээ



Баянхонгор сумын хэмжээнд Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, дадлагыг зохион байгуулахтай холбогдуулан 2025 оны 05 сарын 01-ний өдрийн 16.00 цагт бүх нийтийн зарлан мэдээлэх дохиогоор Оготнотой булгийн “Аюулгүйн цугларах цэг”-т иргэд, олон нийтийг нүүлгэн шилжүүлэлтэд хамт олноороо оролцов.



ЕС.ХЭЛТСЭЭС ЗОХИОН БАЙГУУЛСАН БУСАД АЖИЛ

Албан хаагчдынхаа чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, холбогдох төлөвлөгөөний биелэлтийг хангах чиглэлээр Улсын бүртгэлийн байгууллагын 84 жилийн ой, "Улсын бүртгэлийн ажилтны өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хөтөлбөрийн хүрээнд хэлтсээс дараах ажлуудыг амжилттай зохион байгууллаа. Үүнд: 1. Аймгийн Засаг даргын 2024.01.03-ны өдрийн 01 тоот



захирамжаар 2024 оныг “Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласан бөгөөд энэхүү нэрлэсэн жилийн хүрээнд албан хаагчдынхаа гэр бүлийг урин байгууллага хамт олноо танилцуулж "Гэр бүлийн харилцаа" сэдвээр сургалт зохион байгууллаа.

2 . Улсын бүртгэлийн ажилтны байрын өдөр, хэлтсийн шинэ жилийн баярыг хамтатган тэмдэглэж шинэ оны босгон дээр хөдөлмөр зүтгэлээ үнэлүүлэн Хууль зүй, дотоод хэргийн яамны болон Улсын бүртгэлийн Ерөнхий газрын шагналаар шагнагдсан албан хаагчиддаа шагналыг нь гардуулсан бол Хэлтсийн эцэг эхийн зөвлөлөөс албан хаагчдын шилдэг хүүхдүүдийг алдаршуулан шагнаж урамшууллаа.



АРАВ.ИДЭВХ САНААЧИЛГА, ШИНЭЛЭГ АЖЛЫН ТАЛААР

Манай хэлтэс нь Монгол улсын Үндсэн хууль батлагдсан түүхэн тэмдэглэлт өдрийг жил бүрэн удирдамжийн дагуу тэмдэглэн өнгөрүүлж хэвшсэн бөгөөд 2025 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр хэлтсийн даргын баталсан Удирдамжийн дагуу дараах ажлуудыг зохион байгуулж ажиллалаа.

Энэ удаагийн удирдамжийн зорилго нь **Үндсэн хуулийг** олон нийтэд сурталчлах, албан хаагчдын мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор Үндэсний тодотголтой тал бүрийн арга хэмжээг зохион байгуулж албан хаагчдын багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэхэд оршиж байлаа. Үүнд:

1.Асуулт хариултын тэмцээн /Асуултын хамрах хүрээ/

Монгол улсын 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиудаас хамруулан quiz.com апплейкшн ашиглан 10 асуулт бүхий тэмцээнийг хэлтсийн даргаас зохион байгуулж Э.Адъяабаяр ахлагчтай баг тэргүүлэв.

2.”Үндэсний бичгээр хэн сайхан бичих вэ” сайхан бичгийн уралдаан

Үндсэн хуулиас сонгон А4 бичгийн цаасан дээр нэг нүүрийг бичиж багийн ахлагчаас бусад бүх албан хаагчид оролцож хамгийн сайхан бичигтнээр улсын бүртгэгч Ц.Ганчөдөр, З.Ёндонжамц, бичиг хэргийн эрхлэгч Б.Номин-Эрдэнэ нар шалгарав.

3.Үндэсний хувцасаар гоёж ажиллах

Багийн бүх гишүүд Үндсэн хуулийн өдөр үндэсний хувцас дээлээ өмсөж ажиллан зургаа ирүүлсэн.

4.Шагайн наадгай /төрөл/

Шагай шүүрэх, морь уралдуулах төрлүүдэд баг тус бүрээс нэг хүн оролцож наадан Шагай шүүрэх тэмцээнд гэрээт харуул Н.Галбадрах, морь уралдуулах тэмцээнд бүртгэгч З.Дуламсүрэн нар түрүүлэв. /Багуудын хэлтсийн төв дээрх төлөөлөл оролцсон./

5. Үндсэн хуулиас иргэдэд зориулсан постер бэлтгэж хэлтсийн хаягт байршуулах.

Багуудын бэлтгэсэн Постерыг хүлээн авч хэлтсийн дарга дүгнэж байр эзлүүлсэн. 1 дүгээр байрт А.Оюунсүвд ахлагтай багийн постер, 2 дугаар байрт Э.Адъяабаяр ахлагчтай багийн постер, 3 дугаар байрт Т.Мягмарсүрэн ахлагчтай багийн постер тус тус шалгарч хэлтсийн цахим хаягт байршуулан иргэдэд сурталчилж ажиллалаа.

Удирдамжийн дагуу зохион байгуулагдсан тэмцээнүүдийн нийлбэр дүнгээр улсын бүртгэгч Э.Адъяабаяр ахлагчтай баг Тэргүүн байр эзлэн ажлын нэг өдрийн цалинтай чөлөө авах шагналаар шагнуулж баг хамтын ажиллагааны үр дүнгээ дүгнүүлээ.

Мөн энэ өдөр хэлтсийн даргын өрөөнд Монгол улсын Үндсэн хуулийг дээдлэн залж байршууллаа.



Тус хэлтсээс улсын бүртгэлийн явуулын төхөөрөмжийг ашиглан улсын бүртгэлийн үйлчилгээг газар дээр нь хүргэж, улсын бүртгэлийн үйлчилгээний хүртээмжтэй, шуурхай байдлыг нэмэгдүүлэх зорилтыг хангах арга хэмжээний хүрээнд суманд үзүүлдэггүй улсын бүртгэлийн үйлчилгээг хүргэх зорилгоор "Иргэдэд ойрхон улсын бүртгэлийн үйлчилгээ" уриан дор "Нэг цэг"-ийн үйлчилгээг үзүүлэхээр Удирдамж батлан 2025 оны 01 дүгээр сарын 23, 24-ны өдрүүдэд Жинст, Богд сумдад зохион байгууллаа. Тодруулбал, суманд үзүүлдэггүй улсын бүртгэлийн үндэсний энгийн цахим гадаад паспортын үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж, эрх зүйн туслалцаа үзүүлэх, улсын бүртгэлийн зөвлөн туслах үйлчилгээг үзүүллээ."Нэг цэг"-ийн үйлчилгээгээр Жинст сумын 23 иргэн, Богд сумын 80 иргэн, нийт 103 иргэн үндэсний энгийн цахим гадаад паспортын бүртгэлийн үйлчилгээ авсан бол харин Зөрчлийн тухай хуульд заасны дагуу 4 иргэнд зөрчлийг хэрэг үүсгэн, газар дээр нь хянан шийдвэрлэж, шийтгэл ногдуулсан байна. Мөн иргэний улсын бүртгэлийн мэдээллийн цахим санд иргэний мэдээллийн зөрүүтэй байдлыг арилгахтай холбоотой 4 иргэний өргөдлийг хүлээн авч, хянан шийдвэрлэлээ.

Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газраас 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 1Б/199 дугаарт “Нэг хамт олон-Нэг сайн дурын ажил” аян зохион байгуулах тухай албан бичиг ирүүлсэн бөгөөд хэлтсийн албан хаагчид контент бэлтгэн бүх нийтэд байгаль дэлхийгээ хайрлах, хогоо хаяхгүй байх, олон нийтийн газар биеэ зөв авч явах агуулгыг харуулж бэлтгэн цахим орчинд түгээн ажиллав. <https://www.facebook.com/bayankhongor.burtgel.gov.mn/videos/1064791005480263/>

Хэлтсийн Баянцагаан сумд ажиллах улсын бүртгэгч Ц.Цэндийн гэр нь 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр албан үүргээ гүйцэтгэж байх хугацаанд гал түймэрт өртөж шатсан. Хэлтсийн хамт олны зүгээс бүртгэгч Ц.Цэндэд сэтгэлийн дэм болгож 3720000 төгрөгийн хандивыг дансанд нь шилжүүлж, хандивт нэгдэх уриалгыг бэлтгэн хэлтсийн цахим хаягуудад байршуулан ажилласан. Гал түймрийн улсын хяналтын байцаагчийн акт 2025 оны 05 сарын 09-ний өдөр гарсныг улсын бүртгэгч Ц.Цэнд ирүүлснийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт уламжлан тусламж олгох шийдвэрийг гаргуулаад байна.

2025 онд Улсын бүртгэлийн байгууллагын 85 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан хэлтсээс дараах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

1.Хэлтсээс Улсын бүртгэлийн байгууллагын 85 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын төлөвлөгөөнд туссан дагуу 5 дугаар сарын 8-9-ний өдрүүдэд албан хаагчдын 2025 оны Нэгдсэн сургалтыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулж явуулав. Мөн энэ үеэр “Ахмадаа сонсьё” дурсамж уулзалтыг зохион байгуулж ахмадууддаа хүндэтгэл үзүүлсэн бол албан хаагчдад үе үеийн албан хаагчдын сургалт зөвлөгөөн, ажил амралтын үеийн дурсамжуудыг хуваалцан зургийн цомгоор үзэсгэлэн гаргаснаараа энэ удаагийн сургалт онцлог байлаа.



Улсын бүртгэлийн байгууллагын 85 жилийн ойг угтан Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан /Нэгдсэн сургалтын цаг хугацаа таарсан тул/ Хамт олныхоо гэр бүлийн хүрээнд “Хайр түгээе” арга хэмжээг удирдамж, хөтөлбөрийн дагуу зохион байгуулж явууллаа.

арга хэмжээ нь байгууллагын уур амьсгалыг эерэгээр шинэчилж, хамт олны болон гэр бүлийн холбоог бэхжүүлэх, уламжлалт соёлыг дэмжих ач холбогдолтой үйл ажиллагаа болж өндөрлөлөө.

Хамт олны баг, хамтын ажиллагааг сайжруулах, өөрсдийн эрүүл аюулгүй байдалдаа анхаарч багахан ч гэсэн асуудлыг шийдэхээр хэлтсийн даргаас санаачлан дэмжиж 2025 оны 5 дугаар сарын 18-ны Ням гарагийн амралтын өдөр тус хамт олон аймгийн хойд хэсэгт орших Хөшөөгийн ам гэх газар 0.4 га талбайд хүнсний ногоо – төмс, манжин, лууван – тариалж, усалгаа арьчилгааг чөлөөт цагаараа хийн ажиллаж байна. Энэ талаарх мэдээллийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт хүргүүлснээр цахим хаягуудад байршуулан сурталчилан ажиллаж байна.



Олон улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тусгай удирдамжийн дагуу тэмдэглэн өнгөрүүллээ. Удирдамжийг Албан хаагчдын хүүхдүүдийн дунд насны ангилалд тохирсон уралдаан зохион байгуулж, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх авъяас чадварыг дэмжих замаар Эх орон, үндэсний бичгийг сурталчлан таниулах зорилготойгоор хэрэгжүүлсэн юм.

Уралдаан зохион байгуулагдсан төрөл:

1. 6-10 насны ангилалд Монгол орон, эх нутаг, уул усыг шүтэн биширсэн, төрсөн нутгаа дээдлэсэн утга агуулга бүхий шүлгийг уран тод унших уралдаан
2. 11-15 насны ангилалд “Сайхан бичигтэн” шалгаруулах уралдаан”- Монгол бичгээр Б.Ренчингийн “Монгол хэл” шүлгээс А4 цаасны нэг нүүр хуулан бичиж ирүүлэх.

3. 16-18 насны ангилалд “Улсын бүртгэл миний амьдралд” эссэ бичлэгийн уралдаан.



Уралдааны төрөл тус бүрт эхний 3 байрыг шалгаруулж хүүхэд багачуудаа шагнаж урамшууллаа.

Хөдөлмөрийн аюул байдлын асуудал хариуцсан мэргэжилтнээр бүртгэгч Т.Мягмарсүрэнг томилон ажиллуулахаар аймагт зохион байгуулагдаж буй эрх олгох сертификаттай сургалтанд хамруулаад байна. Сургалтын төлбөрийн 500,000 төгрөгийг Үйлдвэрчний эвлэлийн сангаас гаргасан болно.



ДҮГНЭЛТ, САНАЛ

Улсын бүртгэлийн хэлтэс нь УБЕГ-аас өгсөн зөвлөмж, чиглэлийг баримтлан хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Хэлтсийн албан хаагч, сумдын улсын бүртгэгч нараар дамжуулан бүрэн эрхээ хэрэгжүүлж, 2025 оны үндсэн зорилтоо амжилттай хэрэгжүүлэн ажиллалаа. Дараах саналыг хүргүүлж байна.

Байгууллагын дотоод үйл ажиллагааны хэвийн ажиллах НӨХЦЛИЙГ хангах талаар

Нэг.Бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай чирэгдэлгүй хүргэхэд шаардлагатай тоног төхөөрөмж шинэчлэлтийг шат дараатайгаар хийж байгаа боловч төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн

системд ажиллах нөхцөл боломжгүй буюу ажилтнуудад тус системд ажиллаж боломжгүй байна. Өөрөөр хэлбэл архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийг хэрэгжилт хангагдахгүй нөхцөл байдалтай байна. Энэ нь юу вэ гэхээр бүртгэлийн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд ашигладаг компьютер тоног төхөөрөмж дээр ажилтан гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан, бусад төлөвлөгөө түүний хэрэгжилт, дотоод үйл ажиллагааны бусад албан бичиг баримтыг боловсруулж 100 шэйрт байршуулан бичиг хэргийн ажилтанд дамжуулж байгаа нь дотоод сүлжээ бүхий төхөөрөмжид гадны плаш зөөгчөөр хандан авдаг учир эрсдэл үүсгэж байна. Мөн ер систем ашиглалтад орсноор шат дамжлага, цаг хугацаа, бичиг хэргийн зардал хэмнэхээр бодит нөхцөл бүрдсэн байхад ер систем ажиллуулж ашиглах компьютер байхгүй учраас заавал цаасаар хэвлэн гаргаж байна.

Мөн уг системээр ирсэн явсан бичгийг цахимаар хүлээн авч хяналт тавин хэрэгжүүлж, шийдвэрлэсэн тухай ажиллагааг хариуцсан албан хаагч хийхгүй байгаагаас албан бичгийн шийдвэрлэлтийн бүртгэлд зөрчил үүсгэж байна. Иймд хэлтсийн төвийн албан хаагч бүрт дотоод үйл ажиллагаанд ашиглах компьютер принтер олгуулах саналыг хүргүүлж байна. Системийн ашиглалтыг сайжруулбал цаас, хор, цаг хугацааг хэмнэсэн үр дүн гарах болно.

Хоёр. Бүртгэлийн архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулахад анхаарч орон нутгийн хэлтсүүдэд нягтруулсан шүүгээ, хадгаламжийн нэгжийн хамгаалалтын хайрцаг /A4/ бэлтгэн нийлүүлэх

Гурав. Байгууллагын архивыг нягтруулсан шүүгээгээр хангах

Дөрөв. Цахилгаан эрчим хүч тасарснаар бүртгэлийн үйлчилгээ тасалдах эрсдлийг арилгах зорилгоор 2024 оны Хөгжлийн төлөвлөгөөнд тусган батлууснаар аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөр бага оврын дизель станц худалдан авсан боловч тус дизель станцаа ажиллуулах дизель түлшний санхүүжилт төсөв хөрөнгө төсөвт суугаагүйн улмаас үйлчилгээ тасалдах эрсдэл бий болоод байгаа тул шаардлагатай зардлыг төсөвт тусган батлуулахаар 2026 оны төсвийн төсөлд тооцооллыг хийж хүргүүлсэн тул шийдвэрлэж өгөх.

Албан хаагчдын ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшсэн тогтвортой байлгах талаар

Нэг. Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж мэргэшүүлэх багц сургалтад хамрагдах нөхцөлийг бүрдүүлж ажиллах.

Хоёр. УБЕГ-аас дүүрэг, аймгуудын хэлтсүүдийн ажилтнуудын туршлага солилцох сургалт семинарыг бүсчилж зохион байгуулах

Эдгээр саналыг анхааран шийдвэрлэх нь байгууллага, албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг сайжруулах, бүртгэлийн байгууллагын хэвийн ажиллах нөхцөл боломжийг нэмэгдүүлэхэд ач холбогдолтой байх болно.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.МӨНХЖАРГАЛ